

**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /товчилсон/**

*/Хугацаа: 2019 оны 01 дүгээр сарын 01-ний
өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Оршил

Үндэсний давхар даатгал ХК нь 2019 онд үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02/11 дугаар тогтоолоор батлагдсан компанийн Бизнес төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2019 оны А/10 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус удирдлага болгон ажиллалаа.

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2.1. МИД-ийн үйл ажиллагааг сайжруулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх:

МИД /Малын индексжүүлсэн даатгал/-ын борлуулалт эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах:

Тайлант онд нийт 9 даатгалын компани /Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, Миг даатгал ХХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК/-тай МИД-ын Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ байгуулж, борлуулалтыг 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүллээ.

Мөн ХААН болон Төрийн банктай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, оролцогч даатгалын компаниуд болон дээрх зуучлагч 2 банктай зуучлалын гэрээг байгуулах ажлыг зохион байгуулав.

МИД-ын борлуулалттай холбоотой сурталчилгаа:

МИД-ын борлуулалтыг дэмжиж 2019 оны 6 дугаар сард Дундговь, Өмнөговь, Хэнтий аймгуудад албан томилолтоор ажиллаж, сургалт, сурталчилгаа болон борлуулалтыг идэвхжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

МИД-ын хамрагдалтыг нэмэгдүүлэх, малчдад даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилгоор даатгалын компаниудтай хамтран Архангай аймгийн зарим сумдад 11 дүгээр сард томилолтоор ажиллалаа.

МИД-ын программ хангамжаас болон баталгаанаас илэрсэн алдаа, зөрчлийг засаж залруулах, заавар зөвлөгөө өгөх:

МИД-ын 2019 оны борлуулалтын явцад даатгалын компаниуд болон зуучлагч банкнуудын программд гарсан давхардал, цуцлалт, буруу бичилт гэх мэт алдаа зөрчлийг цаг тухай бүр нь засаж залруулан ажиллав.

МИД-ын 2019 оны борлуулалтыг хаах зорилгоор ХААН болон Төрийн банкны борлуулалтыг хянаж, алдаа зөрчлийг илрүүлэх ажлыг Бизнес хөгжил, төслийн газар, Компаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын холбогдох нийт 8 ажилтан оролцож, цаг хугацаандаа ажлаа хийж гүйцэтгэлээ.

Мөн 2018 оны МИД-ын борлуулалтад зуучлагч банк болон даатгалын компаниудын даатгуулагчийн харьяа сум сольж даатгасан алдаа зөрчлийг залруулан засварлаж борлуулалтыг хаасан.

Зуучлалын борлуулалтын тооцоо:

Сар бүр ХААН банкны зуучлалын борлуулалтын тооцоог нийлж зуучлалын шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд нь шилжүүлэн ажиллалаа. Төрийн банкттай 15 хоног тутам тооцоо нийлж зуучлалын хөлсийг гэрээнд заасан хугацаанд нь компанийн санхүүд мэдээлж шилжүүлэн ажилласан.

Борлуулалтын явцын мэдээг оролцогч талуудад хүргэх:

МИД-ын борлуулалтын мэдээг сар бүр оролцогч даатгалын компани болон зуучлагч банкнуудад хүргэн ажиллалаа. Мөн 7 хоног бүр компанийн удирдлагуудыг МИД-ын борлуулалтын мэдээ болон шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.

МИД-ын борлуулалтын үр дүн:

МИД-ын 2019 оны борлуулалтын хаалтыг 7 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж дуусгав. Хаалтын дүнгээр даатгалын компаниудаас 6,263 борлуулалт 912,385,067 /есөн зуун арван хоёр сая гурван зуун наян таван мянга жаран долоон/ төгрөг, зуучлагч Төрийн банк 14,487 борлуулалт 1,674,800,000 /нэг тэрбум зургаан зуун далан дөрвөн сая найман зуун мянган/ төгрөг, ХААН банк 11,587 борлуулалт 1,258,500,000 /нэг тэрбум хоёр зуун тавин найман сая таван зуун мянган/ төгрөг, нийт **32,337 борлуулалт 3,845,685,067 /гурван тэрбум найман зуун дөчин таван сая зургаан зуун наян таван мянга жаран долоон/ төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүллээ.**

2.2. Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэх:

Эрчимжүүлсэн мал аж ахуйн давхар даатгалын андеррайтинг хийх, гэрээ байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийж, хураамжийг тооцоолж төвлөрүүлэх:

Макс Агро ХХК-ийн сүүний чиглэлийн фермийг 2018 онд даатгасан даатгалын гэрээний үр дүнг дүгнэн судалж, дахин гэрээг сунган 2,017,250,000 /хоёр тэрбум арван долоон сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийн үнэлгээ бүхий үнээний эрсдэлийн үнэлгээг хийж 4.05 хувиар 60:40 хувийн оролцоо бүхий давхар даатгалын гэрээг байгуулан 32,501,250 /гучин хоёр сая таван зуун нэг мянга хоёр зуун тавин/ төгрөгийн хураамж төвлөрүүлэв.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн давхар даатгалын андеррайтингийн үзлэг шалгалтыг хийх, мэдээлэл боловсруулах:

Эрчимжүүлсэн мал аж ахуйн давхар даатгалын гэрээг судлан, 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Макс Агро ХХК-ийн үнээний фермд андеррайтингийн үзлэг шалгалт хийж, зураг аван баталгаажуулж тайлагнав. Тус үнээний фермийн үйл ажиллагааг нягтлан шалгаж 454 үнээнд үзлэг хийн хүзүүний дугаарлалтын хамт зургийг авч баталгаажууллаа. Үүнээс малын эмчийн дүгнэлтийн дагуу өвчтэй, гэмтэлтэй, хэт туранхай зэрэг шалтгаануудын улмаас 28 үнээг даатгалд хамруулахаас татгалзан 426 үнээг хамруулахаар шийдвэрлэсэн.

Мөн Сонгинохайрхан дүүргийн Эмээлт, 361-ийн гарам, Баруунтуруун зэрэг газруудад эрчимжүүлсэн мал аж ахуйтай аж ахуйн нэгж болон хувь хүмүүс Ард даатгал ХК-д даатгуулах хүсэлт гаргасан. Ард даатгал ХК нь дээрх хүсэлтийг хүлээн авч, манай компанитай хамтран хийх хүсэлтэй байгаагаа ирүүлсний дагуу даатгалын мэдлэг олгох зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр уулзалт, сургалт зохион байгууллаа. Үүний үр дүнд ирэх онд 5 фермийг даатгалд хамруулахаар боллоо.

2.3. Газар тариалангийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэх:

Тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтэц болон даатгалын загварчлалыг судлах, турших:

СКОР /SCOR/ давхар даатгалын компанитай байгуулсан индексжүүлсэн даатгалыг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тариалангийн даатгалын загварчлал боловсруулахад шаардлагатай 2018 онд даатгал хийлгэсэн 11 үрийн аж ахуйн нэгжүүдийн талбай болон эрсдэлийн талаар асуулга авч нэгтгэн СКОР /SCOR/ давхар даатгалын компанийн холбогдох мэргэжилтэнд явуулсан. Дээрх судалгаанд үндэслэн индексжүүлсэн даатгалын загварчлалын эхний шатыг боловсруулсан боловч загварчлал хийж байгаа АНУ-ын Зэд экс /Zed X/ компани цаашид СКОР /SCOR/ давхар даатгалын компанитай хамтарч ажиллах боломжгүй болсон тул Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн хүрээнд хийлгэхээр судалж байна.

ЖАЙКА /Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага/-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай 10 дугаар сарын 11-ний өдөр тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төслийг дэмжихэд туслалцаа авах зорилгоор Хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэнтэй уулзсан. Тус газраас 2020 оны санхүүжилт болон дараа жилийн төлөвлөгөөгөө судалж, санхүүжилт өгөх эсэхээ шийдэхээр боллоо.

Тариалангийн улаан буудайн даатгалаас өөр бүтээгдэхүүнийг даатгах эсэхийг судлах:

Төмс хүнсний ногоог даатгах эрэлт хэрэгцээг судлах зорилгоор 5 дугаар сарын 02-ны өдөр Швейцарын хөгжлийн агентлагийн Монгол ногоо төслийн зохицуулагч Т.Төрмандахтай уулзаж, мэдээлэл солилцлоо. Уулзалтаар төмс, хүнсний ногоо даатгах эрэлт хэрэгцээ их байгаа ба ялангуяа төмсийг даатгах, судлах нь зүйтэй гэж үзэж, судалгааг Төв аймгийн Жаргалант сум дээр хийлээ.

Жимс, жимсгэнийн холбооны тэргүүнтэй жимс, жимсгэнийг даатгах эрэлт хэрэгцээг судлах зорилгоор 5 дугаар сарын 07-ны өдөр уулзаж, манай оронд жимс, жимсгэнээс хамгийн их тариалж байгаа чацарганыг даатгах талаар харилцан санал солилцлоо.

Хүлэмжийг даатгах эрэлт хэрэгцээг судлах зорилгоор 5 дугаар сарын 09-ний өдөр ХХААХҮЯ /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж, хүлэмжид учрах эрсдэлүүдийн талаар мэдээлэл солилцож, хүлэмжийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг авч, судалгаа хийлээ. Судалгаанд нийт 52 иргэн, аж ахуйн нэгж оролцож, дийлэнх олонх буюу 80 орчим хувь нь даатгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

“Атар-60” үзэсгэлэнд оролцож, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ эрхлэгчдээс даатгалын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох асуулгыг авсан. Нийт 72 иргэн, аж ахуйн нэгжээс судалгаа аван, нэгтгэсэн. Судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын нийт 56,4 хувь нь даатгалын эрэлт байгааг илэрхийлсэн бөгөөд судалгааны нэгтгэлийг холбогдох бүтээгдэхүүнийг боловсруулахад ашиглаж, хөгжлийн тусламж үзүүлэх байгууллагуудтай уулзан бүтээгдэхүүн хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх юм.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөрийн “Копиа Монгол төв”-ийн Захирал Чой Ман Ёонтой уулзлаа. Уулзалтаар тус улсад хэрэгжүүлж буй газар тариалангийн даатгалын талаар туршлага судалсан бөгөөд тус улсад 2015 оноос индексжүүлсэн даатгалыг төрөөс 80 хувийн эрсдэлийг хариуцаж Хөдөө аж ахуйн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл авлаа. Дээрх байгууллага нь хөдөө аж ахуйтай холбоотой сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд манай компанийн төлөөллийг сургалтын үйл ажиллагаанд нь хамрагдахад дэмжлэг үзүүлэхээр болсон.

Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулахад саналаа өгөх, холбогдох судалгааг хийх:

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн Удирдах хорооны хуралд 3 дугаар сарын 27-ны өдөр оролцлоо. Тус хуралд тариалангийн салбарын эрсдэлийн удирдлага 1 бүрэлдэхүүн хэсэг нь болж байгаа бөгөөд энэ талаар оролцогч талуудтай санал солилцсон. Цаашид тариалангийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал дээр хамтарч ажиллахаар болов. Мөн тус төслийн холбогдох дарга, мэргэжилтэнтэй 5 дугаар сарын 02-ны өдөр уулзаж, тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн ажлын явцын талаар харилцан санал солилцлоо.

Даатгалын компаниудтай хамтарч ажиллах, борлуулалтад бэлтгэх:

Улаан буудайн даатгалыг хэрэгжүүлэх даатгалын компанийг сонгох зорилгоор 5 дугаар сарын 24-ний өдөр Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК, Практикал даатгал ХХК-ийн холбогдох дарга, мэргэжилтэнтэй уулзаж, улаан буудайн даатгалын үр дүн болон энэ жилийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар харилцан санал солилцсон. Дээрх уулзалтын үр дүнд 2019 оны борлуулалтыг Ард даатгал ХК болон Бодь даатгал ХК хэрэгжүүлэхээр болж, 6 дугаар сарын 01-ний өдөр “Хөдөө аж ахуйн хувь оролцооны давхар даатгалын гэрээ”-г байгуулав. Тус гэрээгээр дээрх 2 даатгалын компани нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний 90 хувийг Үндэсний давхар даатгал ХК-д шилжүүлж байгаа юм. Оролцогч даатгалын компаниудын тариалангийн даатгал хариуцсан ажилтнуудад сургалт хийж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Тариан талбайд андеррайтингийн үзлэг шалгалт хийх:

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалыг хэрэгжүүлэх, андеррайтингийн шийдвэр гаргах зорилгоор талбайд эхний хяналт шалгалтыг Ард даатгал ХК болон Бодь даатгал ХК-ийн төлөөлөлтэй хамтран Үндэсний давхар даатгал ХК-ийн ахлах андеррайтер, агрономич нар 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 25-ны өдрүүдэд Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Хөвсгөл аймгийн улаан буудайн үр үржүүлэх зөвшөөрөл авсан 9 компанийн 1400 орчим га талбайн хяналт шалгалтыг хийлээ.

Дээрх үзлэг шалгалтын үр дүнд Буянт төв ХХК, Алтан залаа ХХК, Газар өгөөж ХХК, Их шинэстэй ХХК, Эг тариа ХХК-ийн **782 га** талбайг даатгаж, нийт **32,846,083 /гучин хоёр сая найман зуун дөчин зургаан мянга наян гурван/** төгрөгийг даатгуулагчдаас төвлөрүүлсэн. Үүнээс Үндэсний давхар даатгал ХК-ийн давхар даатгалын хураамж болох **29,561,475 /хорин есөн сая таван зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун далан тав/** төгрөгийг хувь оролцооны гэрээний дагуу төвлөрүүлсэн.

2.4. Хөрөнгийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

Хөрөнгийн давхар даатгалын эрсдэлийн судалгаа, андеррайтинг хийх, гэрээ болон баталгаа байгуулах, хураамжийг төвлөрүүлэх:

Дотоодын даатгалын компаниуд болон гадаадын давхар даатгалын компаниудын хооронд байгуулсан гэрээнүүдийг судлан хөрөнгийн давхар даатгалын гэрээний загвар боловсруулж даатгагч нартай гэрээ байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд хөрөнгийн даатгалаар нийт 107.2 тэрбум төгрөгийн хариуцлагыг давхар даатгаж, 238.2 сая төгрөгийн даатгалын хураамжийн гэрээ болон баталгааг байгууллаа. Мөн тайлант хугацаанд нийт 500.0 мянган ам.доллар болон 2.0 их наяд төгрөгийн хариуцлагын давхар даатгалын үнийн саналыг боловсруулж даатгалын компаниуд руу явуулсан.

Оролцогч талуудад давхар даатгалын талаарх сургалт зохион байгуулах:

Оролцогч даатгагчдын төлөөлөгч нар, малчид, сум орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд 9807-0770 нээлттэй утсаар дамжуулан МИД болон компанийн бусад бүтээгдэхүүний талаар заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Хөрөнгийн давхар даатгалын андеррайтингийн үзлэг шалгалтыг хийх, мэдээлэл боловсруулах:

Бодь Даатгал ХК-тай хамтран даатгасан Таван Богд Моторс ХХК-ийн үл хөдлөх хөрөнгө, Таван Богд Фудс ХХК-ийн KFC-ийн Энхтайваны өргөн чөлөө, Зайсан салбарууд, Таван Богд группийн агуулахад тус тус газар дээр нь очиж үзлэг хийлээ.

2.5. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

Монгол даатгал ХК, Бодь даатгал ХК, Мандал даатгал ХК, Миг даатгал, Ард даатгал ХК-аас гэнэтийн осол болон эрүүл мэндийн даатгалын үнийн санал авч судалж, харьцуулалт хийснээр гэнэтийн осол болон эмчилгээний даатгалуудад гэрээний загвартай болсон.

2.6. Ачааны болон хариуцлагын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

Ачааны болон хариуцлагын даатгалын зах зээлийн судалгаа хийх:

Ачаа тээвэр болон хариуцлагын даатгалын хүрээнд асуулгын загвар бэлтгэхдээ дотоодын даатгалын компаниуд болох Монре даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Мандал даатгал ХК зэрэг байгууллагуудтай холбоо тогтоон, шаардлагатай мэдээллүүдийг солилцон ажилласны дүнд асуулгын загвартай болсон. Тайлант хугацаанд ачаа тээврийн даатгалаар нийт 398,9 сая төгрөгийн хариуцлагыг давхар даатгаж, 10.3 сая төгрөгийн даатгалын хураамжийн гэрээ болон баталгааг байгууллаа.

Хариуцлагын даатгалын андеррайтинг хийх, давхар даатгах:

Тайлант хугацаанд хариуцлагын даатгалаар нийт 12.9 тэрбум төгрөгийн хариуцлагыг давхар даатгаж, 65.7 сая төгрөгийн даатгалын хураамжийн гэрээ болон баталгааг байгууллаа.

Мөн тайлант хугацаанд нийт 6.5 тэрбум төгрөгийн хариуцлагын давхар даатгалын үнийн саналыг боловсруулж даатгалын компаниуд руу явуулсан.

2.7. Программын сайжруулалт, өөрчлөлт хийх:

Компанийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан бүх ажилтнуудын мэйл хаягуудыг шинэчилж, холбогдох өөрчлөлт тохиргоог хүн бүрд хийж өгсөн. Байгууллагын принтерийг шинэчилж ажилтан тус бүрээр тохиргоог хийж өгсөн Ажилтнуудын компьютерт тогтмол үйлчилгээ хийж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Давхар даатгалын программ хангамж боловсруулахаар сонгогдсон Финтек Солюшн ХХК-ийн төлөөлөлтэй уулзалтууд хийж, хийгдэх ажлын цар хүрээ, хугацааг тохиролцон программ хангамж боловсруулах ажлыг эхлүүлсэн. Давхар даатгалын программын МИД-ын хэсгийг боловсруулж дууссан ба засвар сайжруулалт, программын ажиллагааг шалгах ажлууд хийгдэж байна. Финтек Солюшн ХХК-ийн хүсэлтээр шинээр боловсруулж байгаа программ хангамжаа суурилуулах сервер компьютеруудыг ажилд бэлтгэсэн. Үүнд үндсэн 1 физик серверийг 2 виртуал сервер болгон бэлтгэж хандах эрхүүдийг тус тус хүргүүлсэн.

2.8. Олон улсын давхар даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах:

Олон улсын давхар даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах:

Олон улсын давхар даатгалын гэрээг байгуулах, компанийн даатгалын болон давхар даатгалын чадавхыг бэхжүүлэх үүрэг бүхий давхар даатгалын брокерыг сонгон шалгаруулах Эрсдэлийн хорооны хурлыг 7 дугаар сарын 04-ний өдөр хийлээ. Тус хурлаар Монгол Улсын даатгалын зах зээл үйл ажиллагаа явуулдаг Жи Би Бода /J.B.Voda/, Ю Ай Би Азия /UIB Asia Reinsurance Brokers Pte Ltd/, Тисерс-Интегро /TYSERS-Integro Insurance Brokers Ltd./ зэрэг даатгалын зуучлагч компаниудын талаарх мэдээллийг нэгтгэж танилцуулсан. Хурлаар Жи Би Бода /J.B.Voda/-ыг сонгож, цаашид хамтран ажиллахаар болсон. Иймд тус компанитай хамтран ажиллахаар болсны дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн 2020 оны урьдчилсан хураамжийн орлогыг тооцоолж, тус брокерт явууллаа. Дээрх мэдээлэлд үндэслэн СКОР /SCOR/, Жи Ай Си Рэ /GIC Re/ давхар даатгагч нараас хөрөнгө /тусгай зориулалтын хүнд машин механизм/, хариуцлага, ачаа тээвэр, барилга угсралт, гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг трити гэрээгээр давхар даатгах үнийн саналууд ирсэн.

Үнийн саналуудыг нэгтгэн танилцуулга бэлтгэж, Захирлын зөвлөлийн хуралдаанаар танилцуулсан бөгөөд 12 дугаар сарын 01-ний өдөр трити гэрээг байгууллаа. Тус гэрээнд тэргүүлэгч давхар даатгагч СКОР /SCOR/ 40 хувиар, Жи Ай Си Рэ /GIC Re/ 30 хувиар, Ханновер Рэ /Hannover Re/ 25 хувиар, Тайпин Рэ /Taiping Re/ 5 хувиар тус тус оролцож байгаа болно.

Бүтээгдэхүүний эрсдэлийн тодорхой хэсгийг олон улсын давхар даатгагчид хамруулсан давхар даатгалын хураамжийг шилжүүлэх:

МИД-ын дээд болон дунд түвшний эрсдэлийг олон улсын давхар даатгалд хамруулах зорилгоор дараах ажлуудыг хийлээ.

МИД-ын дунд түвшний давхар даатгалд хамруулах эрсдэлийн хэмжээг төлөвлөж буй нийт хураамжийн 60 хувь давсан 130 хувь болон 65 хувь давсан 125 хувиар тогтоон хамтран ажилладаг Ханновер Рэ /Hannover Re/, СКОР /SCOR/, АсиаКапитал /Asia Capital/, КатарРэ /QatarRe/ гэсэн олон улсын давхар даатгалын компаниудад үнийн санал ирүүлэх хүсэлтийг албан захиагаар хүргүүлсэн. Давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналуудыг судалж үзээд, хамгийн бага үнийн санал ирүүлсэн СКОР /SCOR/ давхар даатгагчид нийт хураамжийн 65 хувь давсан 125 хувиар давхар даатгуулах гэрээг 9 дүгээр сарын 01-ний өдөр байгуулав.

МИД-ын дээд түвшний давхар даатгалд хамруулах эрсдэлийн хэмжээг төлөвлөж буй нийт сонгосон үнэлгээний 0.3 хувь давсан 2.97 хувь болон 0.2 хувь давсан 2.97 хувиар тогтоон хамтран ажилладаг Ханновер Рэ /HannoverRe/, СКОР /SCOR/, АсиаКапитал /Asia Capital/, КатарРэ /QatarRe/ гэсэн олон улсын давхар даатгалын компаниудад үнийн санал ирүүлэх хүсэлтийг албан захиагаар хүргүүлсэн. Давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналуудыг судалж үзээд, хамгийн бага үнийн санал ирүүлсэн СКОР /SCOR/ давхар даатгагчид нийт сонгосон үнэлгээний 0.3 хувь давсан 2.97 хувиар давхар даатгуулах гэрээг 9 дүгээр сарын 07-ны өдөр байгууллаа. 2019 онд МИД-ын бүтээгдэхүүний хүрээнд 13.33 тэрбум төгрөгийн эрсдэл даах чадавхтай боллоо.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний 75 хувийг СКОР /SCOR/ давхар даатгалын компанид даатгуулах хөдөө аж ахуйн хувь оролцооны давхар даатгалын гэрээг 6 дугаар сарын 01-ний өдөр байгуулж даатгууллаа.

ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙЖ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАЖ ТУРШИХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1. Давхар даатгалын үйл ажиллагааг сайжруулах, орлого нэмэгдүүлэх:

Дотоодын зах зээлийн судалгааг хийж, дотоодод хэрэгжиж байгаа ердийн даатгалын хэлбэрүүдээр давхар даатгал хийх нөөц бололцоог судлах:

ХААН банканд зориулсан санхүүгийн лизингийн даатгалын талаар ХБНГУ-ын Холбооны экспортын зээлийн батлан даалтын агентлагийн туршлагаас судаллаа. Лизингийн даатгал нь:

- Хураамжийн дээд үнэлгээ-Нийт зээлийн дүнгийн 75 хувь
- Хураамжийн хувь-3 хувь
- Нөхөн төлбөр олгох хугацаа-3 сар
- Даатгах эрсдэл-зээлдэгч хуулийн этгээд дампуурсан, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас техник, тоног төхөөрөмжид хохирол учирч бизнес тасалдсан зэргээр даатгалын бүтээгдэхүүний нөхцөлийг боловсруулж ХААН банканд санал болголоо.

Дотоодод хэрэгжиж байгаа ердийн даатгалын хэлбэрүүдээр даатгалын компаниудын 2018 оны даатгалын хураамжийн нийт орлого, цэвэр орлого, давхар даатгалын хураамжийн зардал, даатгалын хураамжийн буцаалт, нийт нөхөн төлбөрийн зардлын мэдээллийг дэлгэрэнгүй тусгасан давхар даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг гаргаж холбогдох удирдлагууд болон ажилтнуудад өгөв.

Бизнес тасалдлын даатгалын андеррайтинг хийхэд тусалцаа үзүүлэх зорилгоор танилцуулга, нөхөн төлбөр, тооцоолол зэргийн гарын авлага бэлтгэн ажиллалаа. Уг даатгал нь ямар нэгэн шалтгааны улмаас хөрөнгийн даатгалаар хамгаалагдсан хөрөнгөнд гэмтэл, хохирол гарсны улмаас бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нөлөөлөх, бараа эргэлтийг бууруулах, нийт ашигт нөлөөлөхөөс хамгаалах зорилготой юм.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болон хувийн аж ахуй нэгжүүдийн 2019 онд зарлах даатгалын тендерүүдийн мэдээллийг цуглуулж 2019 оны тендерийн жагсаалтыг гаргалаа. Уг жагсаалтад бизнес төлөвлөгөөнд тусгагдсан давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх даатгалын хэлбэрүүдээр зарласан тендерүүдийг оруулсан болно. Мөн Монгол Улсад лизингийн үйлчилгээ эрхэлж буй 37 аж ахуйн нэгж, 13 арилжааны банкнуудын судалгаа хийв.

Оюу толгой ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгч КАМЛ /CAML/ ХХК-ийн ил уурхайн мэргэжлийн болон ерөнхий хариуцлагын даатгалын талаар судалгаа хийж бэлтгэн эрсдэлийн хороонд танилцуулсан.

Тэсо корпорац нь ачаа тээвэрт зориулсан программ хөгжүүлж зах зээлд гаргах гэж байгаа ба үүнтэй холбоотойгоор ачаа тээврийн даатгалын шинэ бүтээгдэхүүн боловсруулж өгөх хүсэлтийг манай компанид гаргасан. Уг хүсэлтийн дагуу шаардлагатай судалгааг боловсруулан ажиллалаа.

Гоёо ХХК-ийн тоног төхөөрөмжийн даатгал, Олон улсын дунд сургуулийн үл хөдлөх хөрөнгийн даатгалын талаар судалж, танилцуулга бэлдэн Эрсдэлийн хорооны хурлаар танилцуулав.

Говь ХК-нд экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүн санал болгох, танилцуулах зорилгоор танилцуулга материал, асуулгын маягтыг бэлтгэж хүргүүлэв. Говь ХК-аас бараа зээлээр худалдан авагчдын жагсаалтыг авч зээлдэгчдийн эрсдэлийн шинжилгээ хийн хамтран ажиллахаар судлав. Мөн экспортын худалдааны зээлийн бүтээгдэхүүний талаарх хийсэн уулзалтын үр дүнд уг компаниас нууцад хамаарахгүй төрлийн экспортын худалдааны зээлийн мэдээллийг авч Олон улсын зээлийн брокеруудын холбоо буюу Ай Си Би Эй /ICBA/ болон Малакут Ру /Malakut Ru/ компаниуд руу хүргүүлсэн.

Геосан ХХК-ийн агаарын хөлгийн давхар даатгал хийх зорилгоор агаарын хөлгийн даатгалын зүйл, агаарын хөлгийн их бие, эд ангиуд, эрсдэлийн төрлийн судалгааг хийж, агаарын хөлгийн давхар даатгалын талаар “Практикал даатгал” ХХК-аас ирүүлсэн санал,

давхар даатгалын слип /хувь оролцооны/ гэрээг судлан, мэдээллийг бэлтгэн Эрсдэлийн хороонд танилцуулсан. Нийт хариуцлагын 10 хувийг давхар даатгах Давхар даатгалын баталгааг 4 дүгээр сарын 24-ний өдөр Практикал даатгал ХХК-тай байгуулсан.

Жи Би Бода & Көү Пи Ти И /J.V.BODA & CO PTE/ Ltd брокерын компанитай байгуулах агаарын хөлгийн давхар даатгалын слип гэрээний төслийг боловсруулсан. Мөнх даатгал ХХК, Бодь Даатгал ХК нарын трити гэрээний хүсэлт, мэдээлэлтэй танилцав.

Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогчтой Гүйцэтгэх захирал болон Бизнес хөгжил, төслийн газрын дарга нарын хийсэн бизнес уулзалтыг зохион байгуулав. Уулзалтаар хоёр байгууллага цаашид хэрхэн хамтран ажиллаж болох талаар санал солилцож дахин уулзалт хийхээр болсон.

Монгол даатгал ХК-аас ирүүлсэн Скай Хайпермаркет ХХК-ийн хөрөнгийн даатгал, бараа материалын даатгал, тоног төхөөрөмжийн даатгал болон бизнес тасалдлын даатгалын материалтай танилцсан ба нийт 125.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй бөгөөд даатгалын мэдээлэлд 3 салбар дэлгүүрийн барилгын асуулга хуудас болон өмнө гарч байсан хохирлын талаар, мөн сүүлийн жилийн санхүүгийн мэдээлэл багтсан.

Эрдэнэс Монгол ХХК-ийн хүсэлтийн дагуу автозамын байгууламжийн даатгалын бүтээгдэхүүний танилцуулга боловсруулав.

Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх талаар шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, холбогдох уулзалт, сургалт, семинар зохион байгуулах:

Бодь даатгал ХК-ийн төлөөлөлтэй хамтран ХААН банкны даатгалын зуучлалын алба, Жижиг дунд бизнесийн газар болон Лизингийн бизнесийн газрын төлөөллүүдэд шинэ бүтээгдэхүүн танилцуулах, борлуулах, хамтран ажиллах уулзалтыг 01 дүгээр сарын 09-ний өдөр хийлээ. Уулзалтаар ХААН банкнаас тусгай зориулалтаар санхүүгийн лизингийн зээл авах зээлдэгчдийн төлбөр тасалдах эрсдэлийг хаах лизингийн даатгалыг танилцуулж хамтран ажиллах талаар ярилцлаа. ХААН банкны зүгээс 2019 онд 20.0 тэрбум төгрөгийн багцыг санхүүгийн лизингийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн ба уг зээлийн багцыг даатгаж болох тухай санал тавив.

Санхүүгийн лизингийн даатгалын судалгаа хийж, холбогдох танилцуулга, гэрээний загвар, өргөдлийн маягыг боловсруулсан.

Төлбөр хамгааллын даатгалын бүтээгдэхүүний судалгаа хийж танилцуулга бэлдэв. Энэ нь гэнэтийн ослын улмаас шууд болон шууд бусаар даатгуулагчийн бие махбодод учирсан бэртэл гэмтэл, амь насанд хохирол учирч хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдсаны улмаас орлого олох боломжгүй болж өмнөх өр зээлээ төлж чадахгүй хүрэх, санхүүгийн дарамтад өөрөө болон гэр бүлээ оруулахаас урьдчилан сэргийлсэн хамгаалалт бүхий олон улсын жишиг санхүүгийн хамгаалалтын даатгалын бүтээгдэхүүн юм.

Тус компани Үндэсний давхар даатгал ХК болон өргөжсөнтэй холбогдуулан компанийн үйл ажиллагааг нийтэд сурталчлах, төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн 88, төрийн болон төрийн өмчийн оролцоотой 52, даатгалын үйлчилгээ үзүүлэгч компани болон зуучлагч 60 байгууллагууд руу хамтын ажиллагааны тухай албан бичиг болон компанийн танилцуулгыг хүргүүлжээ. Уг ажлын хүрээнд:

- Хувийн хэвшлийн давхар даатгалын компани болох Хубилай давхар даатгал ХХК-тай 3 удаагийн уулзалт зохион байгуулж хамтран ажиллах гэрээ байгуулав.
- ХААН банктай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Уг санамж бичгийн хүрээнд тариалангийн даатгал, санхүүгийн түрээсийн даатгал, хөрөнгө оруулалтын зээлийн төлбөр тасалдлын даатгал, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд оролцогчдод

- зориулсан төслийн даатгал болон зах зээлд шаардлагатай бусад даатгалын үйлчилгээ үзүүлэхэд харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай заасан.
- Ковэр Хилл давхар даатгалын зуучлагч байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийж хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар тохиролцсон бөгөөд давхар даатгалын зуучлалын гэрээний төслийг бэлтгэв.
 - Амар даатгал ХХК, Номин даатгал ХХК, Ард даатгал ХК, МИГ даатгал” ХХК, Монре даатгал ХХК, Соёмбо брокер, Ай Ай Би ХХК, Улаанбаатар даатгал ХХК, Хаан даатгал ХХК, Монгол даатгал ХК зэрэг компаниудтай хамтын ажиллагааны гэрээ тус тус байгууллаа.
 - Албан бичиг явуулсан газруудтай холбогдож, даатгал, давхар даатгалын судалгааг гаргав. Зарим байгууллагууд /Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК, Эрдэнэс-Таван Толгой ХК, Улаанбаатар Төмөр Зам ХНН/ хариу албан бичиг ирүүлсэн. Судалгааны үр дүнд 2020 оны төлөвлөгөөнд тусгаж хамтран ажиллах боломжтой саналыг илэрхийлсэн юм.
 - Таван Богд Трейд ХХК-тай удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулан, Таван Богд группийн нийт компаниудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож, цаашид хамтран ажиллах бүрэн боломжтой болсон.
 - Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгээс холбогдож, хөрөнгийн даатгалыг 2020 оноос хийлгэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бөгөөд манай компанийн зүгээс хөрөнгийн үнэлгээ хийх асуулгын маягт хүргүүлсэн.

Хүнд өвчний эрсдэлийн даатгал /Critical illness insurance/-ын судалгааг хийж, загварыг боловсруулан танилцуулав. Тус даатгал нь хорт хавдар, цус харвалт, түлэгдэлт, зүрхний шигдээс, тархи нугасны саажилт, бөөрний дутагдал зэрэг үхлийн аюултай 30-аас 36 ширхэг өвчнийг даатгалд хамруулж эдгээр өвчнөөр өвдсөн тохиолдолд эмчилгээний зардал, амь насаа алдсан тохиолдолд ар гэрийнхэнд нь нөхөн олговор өгдгөөрөө тухайн даатгуулагчийг болон түүний ар гэрийг санхүүгийн дарамтад оруулахгүйгээр эмчилгээ хийлгэж эдгэрэх боломжийг олгодог, өндөр хөгжилтэй орнуудад хамрагдалт өндөртэй байдаг даатгал юм. Энэ даатгалд хамрагдахад нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл нь даатгуулагчийн нас байдаг байна.

Богд хааны ордон музейн соёлын биет өвийн даатгалын бүтээгдэхүүн буюу музейн үзмэрийн даатгалын бүтээгдэхүүнийг судалж, танилцуулга бэлтгэлээ.

Шангри-ла Улаанбаатар ХХК-ийн Хөрөнгийн менежментийн газарт давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх хүсэлт, албан бичгийг хүргүүлэв.

Монос группийн Инвестос ББСБ-ийн гүйцэтгэх захиралтай уулзалт хийж, компанийн үйл ажиллагааны талаар танилцуулж, хамтран ажиллах санал тавьсан.

Богд банк нь олон улсын хөрөнгө оруулагчдаас зээлийн шугам нээлгэн хөрөнгө оруулалт татах гэж буйтай холбогдуулан зээлийн даатгалд даатгуулах болсон юм. Уг даатгалд олон улсын давхар даатгагчдаас үнийн санал авах, хамтран ажиллах хүрээнд уулзалт хийлээ. Богд банкны Бизнесийн төвийн захирал, эдийн засагч нартай давхар даатгалын ахлах менежер уулзсан ба санхүүгийн даатгал, зээлийн даатгалын талаар мэдээлэл өгч банкны зүгээс шаардлагатай мэдээллүүдийг нэгтгэн авч олон улсын давхар даатгалын зуучлагч Жи Би Бода /J.V.Boda/-д хүргүүлсэн.

Компани олон улсын давхар даатгагчтай трити гэрээ байгуулах болсонтой холбогдуулан олон улсын брокер компаниудын танилцуулга Жей Би Бода /J.V.Boda/, Ю Ай Би Азия /UIB Asia Reinsurance Brokers Pte Ltd/, Тисерс-Интегро /TYSERS-Integro Insurance Brokers Ltd./ зэрэг даатгалын зуучлагч компаниудын талаарх мэдээллийг нэгтгэж удирдлагуудад танилцуулан, эрсдэлийн хороонд материал бэлдэж өгсөн.

Азийн томоохон орнууд болох Хятад, Солонгос, Энэтхэг, Тайван, Сингапур, Малайз, Хонг Конг зэрэг Азийн нэр хүнд бүхий 14 орон багтдаг Азийн давхар даатгалын холбооны дээд хэмжээний уулзалт Хонг Конгд 2019 оны 10 дугаар сарын 9-өөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус уулзалтад компанийн удирдлагууд оролцсон бөгөөд уг уулзалтын үеэр Үндэсний давхар даатгал ХК нь Азийн давхар даатгалын холбоонд гишүүнээр элссэн юм.

Судалгааны дагуу шинэ бүтээгдэхүүний үндсэн загвар гаргаж, турших ажлыг хийж хэрэгжүүлэх:

Даатгалын тендер зарласан аж ахуйн нэгжүүдийн талаар удирдлагуудад мэдээлэл өгч, тендерт хамтран оролцох талаар даатгалын компаниудад санал тавин ажиллалаа.

Түмэн шувуут ХХК, Мандал даатгал ХК-тай байгуулсан гэрээ, холбогдох материалуудтай танилцаж, эрсдэл, даатгалын хасалт, даатгалын хураамж тооцооллын талаар саналаа өгөв. Тахианы аж ахуйн даатгалын давхар даатгалын слип гэрээний төслийг боловсруулан гаргалаа.

Давхар даатгалын гэрээ байгуулахад туслалцаа үзүүлэх:

Шинээр судалгаа хийсэн, ердийн даатгалын компаниудтай хамтран ажилласны үр дүнд борлуулалт хийж буй даатгалын бүтээгдэхүүнүүдийн андеррайтинг хийхэд шаардлагатай бүх мэдээлэл, судалгааг бэлтгэлээ.

Бодь даатгал ХК-ийн эрсдэлийн мэргэжилтний хамт Тоёота сервис центр ба Ки Эф Си /KFC/, Пицца хат /Pizza Hut/-ын салбарууд болон агуулахын байранд үл хөдлөх хөрөнгийн даатгал хийхтэй холбогдуулан эрсдэлийн шинжилгээний үзлэг хийв.

Давхар даатгалын гэрээ боловсруулах ажлын хэсгийн ажилд туслах зорилготойгоор Олон төрлийн эрсдэл тус бүр дээрх босгоос давсан хохирлын давхар даатгалын трити гэрээг орчуулав.

Олон улсын давхар даатгагчидтай хамтарч ажиллах санамж бичиг байгуулах:

ОХУ-ын Реюнико компанийн мэргэжилтнүүдтэй цахимаар харилцаж, давхар даатгалын системийн программын үйлдлүүд хийх аргачлалын танилцуулга, үнийн саналыг авч, удирдлагад танилцуулав.

БНЭУ-ын Үндэсний давхар даатгалын компани руу /GIC RE/ давхар даатгалын салбарт туршлага хуваалцах хамтран ажиллах тухай санал илгээв.

БНЭУ-ын олон улсын брокер компани ПИНК /PINC/ -ийн төлөөлөгч нартай уулзалт хийв. Уулзалтаар тус брокер компанийн ажлын туршлага, олон улсын давхар даатгагчтай хийдэг даатгалын хэлбэрүүд болон тус компанитай хамтран ажиллаж болох боломжуудын талаар ярилцлаа. ПИНК брокер компани нь 45 орны даатгал, давхар даатгалын компанитай хамтран ажилладаг бөгөөд санхүүгийн даатгал, экспортын даатгал зэрэг даатгалын хэлбэрүүдээр давхар даатгалын зуучлал хийж байсан туршлагатай, мөн даатгалын чиглэлээр компанийн ажилтнуудад сургалт хийх боломжтой талаар ярилцсан.

3.2. Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах:

Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөө, тайланг боловсруулах:

Компанийн нэр Үндэсний давхар даатгал болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн өгсөн зөвлөгөөний дагуу боловсрууллаа. Бизнес төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг оруулав. Үүнд:

- Компанийн эрхэм зорилго, алсын харааг Үндэсний давхар даатгалын компани болсонтой холбоотой цар хүрээ, утга санааг өргөжүүлэн өөрчилсөн.
- Компанийн үнэт зүйлсийг тодорхойлсон.
- Гадаад орчны шинжилгээ нэмж хийв.
- SWOT шинжилгээ хийж, дүгнэлт оруулсан.
- Стратеги зорилтот хүрэх үйл ажиллагааны эрэмбэ дараалал, цаашдын зорилтыг нэмсэн.
- Эрх зүйн орчин дэд бүлгийг боловсруулан хийлээ.

2019-2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө, давхар даатгалын төлөвлөгөө зэргийг шинэчлэн нэгтгэж, танилцуулга бэлтгэн ТУЗ-д танилцуулав.

Давхар даатгалын эрх зүйн орчныг сайжруулах:

Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-д хамрагдаж чадахгүй байгаа малчдад зориулсан нийгмийн даатгалаас гадуурх хувийн эрүүл мэндийн хүртээмжтэй даатгалын үйлчилгээнд хамруулах зорилго бүхий даатгалын бүтээгдэхүүн боловсруулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хийх “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн эхний загварыг боловсруулан ажиллалаа.

Давхар даатгалын чиглэлээр ажилтнуудыг чадавхжуулах:

ХХААХҮЯ, Азийн Хөгжлийн банк, Монголын Жимс Жимсгэнийн Үндэсний холбоо ТББ-ын хамтарсан Нэмүү өртгийн сүлжээг дэмжих ТА-8960 техник туслалцааны төслийн кластерт /холбогдох бүрэлдэхүүн хэсэг/ оролцогчдын зөвлөлдөх уулзалтад оролцов.

Журам боловсруулах хүрээнд шаардлагатай хууль эрх зүйн акт болон холбогдох судалгааг хийж Үндэсний давхар даатгал ХК-ийн “Даатгагч, даатгалын зуучлагчид шимтгэл олгох, компанийн ажилтанд борлуулалтын урамшуулал олгох журам”-ыг боловсруулан санал аван ажилласан.

3.3. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай судалгааг хийх, хэрэгжүүлэх:

Экспортыг дэмжих төсөл, экспортын шинэ санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэн дэд бүрэлдэхүүн хэсэг 1.1-ийг хангаж ажиллах:

Төслийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан ХХААХҮЯ-нд танилцуулах экспортын даатгалын танилцуулгыг шинэчлэн боловсруулав.

БНЭУ-ын И Си Жи Си /ЕСГС/ экспортын даатгалын корпорацаас Энэтхэг Улсад хүрэлцэн ирж, албан ёсоор санамж бичиг солилцох, ажилтнуудыг экспортын даатгалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад урьсан. Мөн хамтран ажилладаг бусад олон улсын экспортын даатгалын агентлагуудтай харилцаатай ажиллав.

Холбогдох төслүүдтэй хамтарч ажиллах, борлуулалтын суваг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Мэрси Кор Олон Улсын байгууллагын “Дасан зохицох, даван туулах чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн шийдэл ТББ-аас зохион байгуулсан Санхүүгийн хүртээмж ба бизнес хөгжил төслийн хэлэлцүүлэгт 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр оролцов. Уг хэлэлцүүлгээр мал аж ахуйн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар бизнес эрхлэгчид туршлагаасаа хуваалцлаа.

Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор шинэчлэн батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-д сангаас шууд зээл олгох тохиолдолд зээлийн эрсдэлийн болон хөрөнгийн даатгалд зээлдэгчдийг заавал даатгуулна гэж заасан байна.

Уг даатгалд хамтран ажиллах талаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захиралд хамтран ажиллах албан бичиг хүргүүлэн холбогдох уулзалтыг төлөвлөн ажиллаж байна.

Говь ХК-ийн Санхүүгийн газрын захирал, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Өнөболд, Бизнесийн шинжилгээний хэлтсийн дарга нартай 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Бизнес хөгжил, төслийн газрын ажилтнууд уулзаж экспортын зээлийн даатгалыг хийх талаар уулзалт хийлээ. Эхний ээлжид Говь ХК-ийн зээлээр худалдан авагчдын мэдээллийг авч эрсдэлийн шинжилгээ хийхээр тохирлоо. Худалдан авагчдын эрсдэлийн шинжилгээ хийж мэдээллээр хангаснаар Говь ХК-ийн экспортын зээлийн даатгалыг хийх боломжтой болсон юм. Уг мэдээлэлд үндэслэн Монгол даатгал ХК-тай хамтран Говь ХК-ийн төлбөр тасалдлын гэрээг боловсруулан гарын үсэг зурж баталгаажууллаа.

Олон улсын санхүүгийн корпорацын Дэлхийн банкны бүлэг, ХХААХҮЯ, Монгол банк, Монголын банкны холбооноос хамтран 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Жижиг дунд бизнесийн хөгжил болон санхүүжилт” сэдэвт зөвлөгөөнд оролцов. Уг зөвлөгөөнөөр Жижиг дунд байгууллагуудын хөгжлийг дэмжих санхүүгийн таатай орчныг бий болгоход төрийн гүйцэтгэх үүрэг болон хэрхэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж Жижиг дунд байгууллагын хөгжлийг дэмжих вэ гэсэн сэдвүүдийн хүрээнд төрийн байгууллагын төлөөлөгчид болон бусад төрийн бус байгууллага, банкны төлөөллүүд, олон улсын байгууллагын төлөөллүүд санал бодол, туршлага солилцлоо. Энэ зөвлөгөөнөөр хэлэлцэж байсан Жижиг дунд байгууллагуудад хамгийн тулгамдаж байгаа асуудал бол гарцаагүй эргэлтийн хөрөнгийн барьцаа зээл болон эрх зүйн таатай орчин гэдгийг хэлэлцүүлэгт оролцогчид дуу нэгтэй хүлээн зөвшөөрч гарах гарц болон олон улсын туршлагын талаар ярилцаж байлаа. Энэ нь манай богино хугацаат эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн даатгалын бүтээгдэхүүн нь Жижиг дунд байгууллагуудын зайлшгүй нэг хөгжлийн гарц болох нь харагдаж байв. Уг форумд оролцож ЖДҮ /жижиг дунд үйлдвэрлэл/-ийг дэмжих сангаас зээл олгох тохиолдолд зээлийн эрсдэлийн даатгал хийх болсон талаар мэдээлэл авч ажиллахаар боллоо.

Олон улсын зээлийн брокеруудын холбоо буюу Ай Си Би Эй /ICBA/-тэй зээлээр экспортын худалдаа хийдэг даатгуулагчдын худалдан авагчдын мэдээллийг авах, зээлдэгчдийн эрсдэлийн судалгаа хийх зэрэг үйлчилгээ үзүүлэхээр холбоо тогтоолоо.

Ди Би Эм Лизинг ХХК-ийн удирдлагуудтай 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр уулзалт хийж, шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт хамтран ажиллах, давхар даатгалын үйлчилгээг үзүүлэх хүсэлтээ илэрхийлж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн давхар даатгалын үйлчилгээг үргэлжлүүлэх болон санхүүгийн лизингийн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулга хийлээ. Уулзалтын үр дүнд тус компанийн зүгээс 2017 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэв. Дүгнэлтээр 2017 онд нийт 161 аж ахуйн нэгжийн 328 ширхэг тоног төхөөрөмжийг даатгах байснаас 61 аж ахуйн нэгжийн 107 ширхэг тоног төхөөрөмж буюу нийт аж ахуйн нэгжийн 37 хувийг даатгалд хамруулсан биелэлттэй ажилласан байна.

Сангийн яамны Санхүүгийн зах зээлийн газарт Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Экспорт Хөтөлбөр”-ийн хэрэгжилтээс компанийн хариуцан хийсэн ажлын хэрэгжилтийг гаргаж өглөө. Үүнд: Экспортын даатгалын тогтолцоог хөгжүүлэх, үйлдвэрлэгчдэд зориулсан уян хатан нөхцөл бүхий санхүүжилтийн хэрэгслүүдийг зах зээлд шинээр нэвтрүүлэх, экспортын санхүүжилтийн тогтолцоог цогц байдлаар бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах зэрэг ажлын товч тайланг өгсөн.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын түнш байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг судлав.

Холбогдох төслүүдтэй хамтарч ажиллах, борлуулалтын суваг нэмэгдүүлэх:

Сибелиус төслийн хүрээнд Ник Волкер ахлагчтай ажлын хэсэг 2019 оны 6 дугаар сарын 20-оос 26-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж буйтай холбогдуулан ажлын хэсэгт туслалцаа үзүүлэн, хамтран ажиллалаа. Уг төслийн үйл ажиллагааг Монгол Улсын туршлагад нийцүүлэх, үр өгөөжийг сайжруулах зорилгоор зохион байгуулж буй хэлэлцүүлэг семинарт 6 дугаар сарын 25-аас 26-ны өдрүүдэд оролцлоо. Сибелиус төслийн хүрээнд 10 дугаар сарын 24-ний өдөр Жак Лиджлей болон Филиппо Контента нартай ээлжит уулзалт хийв. Төслийн бүтээгдэхүүнүүдийг танилцуулах, малчдаас судалгаа авах зорилгоор төслийн ахлах Ник Волкер-тай харилцан санал асуулгын эх бэлтгэв. Уг санал асуулгаар эхний удаад Архангай аймгийн 278 малчнаас судалгаа авсан ба уг судалгааны үр дүнг нэгтгэн хүргүүллээ.

Энэхүү төсөл нь Их Британийн Засгийн Газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн сансрын агентлагаас санхүүжилттэй бөгөөд орчин үеийн хиймэл дагуулаас авсан мэдээллүүдийг ашиглаж МИД-ыг төрөлжүүлэх буюу хиймэл дагуулын мэдээлэлд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, Монгол Улсын малчдын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, санхүүгийн эрсдэлээс хамгаалан амьжиргааг сайжруулах зорилготой 2018-2021 оны хооронд хэрэгжих төсөл юм. Хиймэл дагуулаас авах мэдээлэл нь бүс нутгийн цаг агаарын түүхэн мэдээллийг /хур тунадасны хэмжээ, цасны зузаан, хөрсний шим, салхины хурд гэх мэт/ газар зүйн зураглалаар авах боломжтой технологийн шийдэл юм.

2013 оноос хойш ашигт малтмалын үнэ буурч эхэлснээс хойш хөдөө аж ахуйн салбар, үүний дотор жижиг тариаланчдыг дэмжих нь орлогыг нэмэгдүүлэхээс гадна эрсдэлийг бууруулах чухал салбар болохыг төрөөс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсын хэмжээнд нийт 35,000 ногоочин үйл ажиллагаа явуулж, амьжиргаагаа залгуулж байна. Иймд хүнсний ногоочдыг байгаль цаг уурын өөрчлөлтөөс хамгаалах, ядуурлыг бууруулах, улмаар хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хүнсний ногоочид хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрэлдүүлэх хамгаалалт бий болгох зорилгоор асуулга бэлтгэн ХХААХҮЯ болон бусад холбогдох байгууллагуудтай уулзан нийт 92 иргэн аж ахуйн нэгжээс судалгаа аваад байна.

Санхүүгийн зохицуулах хороо, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ /MEFIN/-тэй хамтран зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, уур амьсгалын эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүнийг Монгол Улсад хэрхэн нэвтрүүлэх, бусад улс орнуудын туршлагыг судлав.

3.4. Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах:

Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлах:

ХААН болон Төрийн банкнаас МИД-ын сурталчилгааны материалын эхийг бэлдүүлэн авлаа. Үүний дагуу Эс Пи Ар /SPR/ хэвлэлийн компанитай шууд гэрээ байгуулан тус бүрээс 500 ширхгийг хэвлүүлэн хамтран ажилладаг даатгалын компаниудад хүлээлгэн өглөө. Тус плакатыг хөдөө орон нутгийн банкны салбаруудад байршуулсан.

Компанийн оноосон нэр солигдож байгаатай холбогдуулан шинэ брендбүүк хийх компанийг судалж үнийн санал авсны дагуу Вайлд ХХК-ийг /Wild agency/ сонгосон юм. Нэг сарын хугацаанд брендбүүкний шинэ загварыг бүрэн хийж дуусган хүлээн авлаа. Брендбүүк шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Тод тамга ХХК-д Гүйцэтгэх захирлын тамга,

санхүүгийн тамга, Төлөөлөн удирдах зөвлөлийн тамгануудыг шинээр хийлгүүллээ. Мөн Ейс /Yes/ хэвлэлийн газраар шинэ туг хийлгүүлэн захирлын өрөөнд байршууллаа. Нийт ажилтнуудад компанийн логотой даавуун тор хийлгүүлэн тарааж өгөв.

Сурталчилгааны материал хэвлүүлэх тендерт шалгарсан Эс Пи Ар /SPR/ хэвлэлийн компанитай хамтран ажиллаж, хэвлэлийн эхийг бэлтгэн, шаардлагатай материалуудыг цаг тухайд нь хэвлүүлэв.

Азиа Майнинг /Asia Mining/ сэтгүүлийн 2 нүүрэнд компанийн сурталчилгааг байршуулан ажиллалаа. Уг сэтгүүл нь нийт 5000 ширхэг хэвлэгдсэн бөгөөд уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хүрээнд зохион байгуулагддаг томоохон формууд болох Коал Монголиа /Coal Mongolia/, Дисковер Монголиа /Discover Mongolia/-ийн үеэр тараагдсан.

Монголын Бизнесийн Зөвлөлийн Наадам фестивалд компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор шторк /сурталчилгааны танилцуулга дүрс бичлэг/-ийг тус үйл ажиллагааг хариуцаж байгаа ажилтанд хүлээлгэн өгч, тус арга хэмжээний үеэр дэлгэцээр сурталчилсан.

Засгийн газрын мэдээ сонины 10 дугаар сарын 22-ны өдрийн хэвлэлтэд Үндэсний давхар даатгал компани Азийн давхар даатгагчдын холбоонд гишүүнээр элссэн тухай мэдээлэл бэлтгэн өгч, хамтран ажилладаг мэдээний сайтуудад давхар байршуулав.

www.mongolianre.com вэбсайтад болон фейсбүүк, твиттер хуудаснуудад компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг шинэчлэн оруулж, компанийн болон давхар даатгалын талаар сонирхсон хүмүүст мэдээлэл өгч ажиллалаа.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ, ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

4.1. Компанийн дүрмийн сангийн хөрөнгийг удирдах:

Дүрмийн сан болон бусад сангуудын 2018-2019 онуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, өгөөжийн тооцоолол хийх:

Үндэсний давхар даатгал ХК 4 дүгээр улиралд хуримтлагдсан ашгаасаа Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг 19.0 тэрбум төгрөг, Дүрмийн сангийн хөрөнгийг 20.0 тэрбум төгрөг болгон өсгөлөө.

Дүрмийн сан, алдагдлаас хамгаалах сан болон бусад сангуудын мөнгөн хадгаламж байршиж буй банкнуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд хугацаандаа хүүгийн орлого орж ирээгүй Төрийн банк, ХААН банк, Худалдаа хөгжлийн банкнуудаас хүүгийн орлогын алдангийг тооцон авсан.

Сар бүр орж ирж буй хүүгийн орлогын тооцооллыг тулган баталгаажуулж, банкнуудын “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам”-ын дагуу Монголбанкнаас хянаж тооцсон тайлангийн хуулбар болон санхүүгийн тайланг авч, банкны холбогдох ажилтнуудтай хамтран ажиллав.

Тайлант онд мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 5.4 тэрбум төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 59.6 сая төгрөг оруулж, компанийн хөрөнгийг өсгөн арвижууллаа.

Дүрмийн сан болон бусад сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох журмын дагуу хөрөнгө оруулалтад байршуулах, орлого төвлөрүүлэх:

Гэрээний хугацаа дуусаж буй мөнгөн хадгаламжийг хөрөнгө зохицуулах журмын дагуу байршуулах ажлыг зохион байгуулан Гүйцэтгэх захирлын 2019 оны А/11 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдааныг хөтлөн, ажлын хэсгийн зөвлөмжийг Гүйцэтгэх захиралд танилцуулан удирдлагын шийдвэрээр банкнуудтай мөнгөн

хадгаламжийн гэрээ байгуулан ажиллалаа. 2019 онд нийт 7 арилжааны банканд хөрөнгө байршуулав.

4.2. Эрсдэлийн сангуудыг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах:

Компанийн эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор заавар, журам бэлтгэн батлуулах:

Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 290 дүгээр тушаалын 2.1-т “Даатгагч энэ зааврын дагуу өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрсдэлийн удирдлагын стратегид тохирохуйц бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, цар хүрээ, харилцан хамааралтай шинж чанарыг харгалзан хамгийн тохиромжтой, хангалттай аргачлал, техникийг багтаасан эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал /цаашид “үнэлгээний аргачлал”/-тай байна.”, 2.2-т “Даатгагч энэ зааврын 2.1-т заасан үнэлгээний аргачлал, түүнд орох өөрчлөлтийг төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах ба баталснаас хойш 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ.” гэж заасны дагуу компанийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлалын төслийг бэлтгэж, холбогдох удирдлагуудад танилцуулан, санал авч, Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан.

4.3. Компанийн хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлэх, шийдвэрлэх:

Гэрээний хугацаа дуусаж буй мөнгөн хадгаламжийг хөрөнгө зохицуулах журмын дагуу байршуулах ажлыг зохион байгуулан Гүйцэтгэх захирлын 2019 оны А/11 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн №01, 3 дугаар сарын 25-ны өдрийн №02, 5 дугаар сарын 13-ны өдрийн №03, 6 дугаар сарын 03-ны №04, 6 дугаар сарын 17-ны №05, 9 дүгээр сарын 18-ны №07, 10 дугаар сарын 29-ний өдрийн №08, 11 дүгээр сарын 04-ний өдрийн №09, 11 дүгээр сарын 20-ны өдрийн №10, 12 дугаар сарын 17-ны өдрийн №11 дүгээр ажлын хэсгийн хуралдааны зөвлөмж, Гүйцэтгэх захирлын шийдвэрийн хамт цаг тухай бүрд нь ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны даргад цахим шуудангаар хүргүүлж ажиллалаа.

Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, хуваарилах хэсгийн 5 дугаар хавсралтад заасны дагуу “Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн байршлын тайлан”-г улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд цаг хугацаанд нь хүргүүлсэн.

4.4. Компанийн эрсдэлийг илрүүлэх, шинжилгээ хийх, хянах:

“Үндэсний давхар даатгал ХК-д учирч болох гадаад болон дотоод эрсдэлүүд” талаар судалгааны ажил хийх үүднээс даатгалын салбарын болон тус компанид учирч болох дотоод болон гадаад эрсдэлүүдийг судаллаа.

Гадаад орчны эрсдэл нь түүхий эдийн үнийн уналт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэргээр дамжин манай төлбөрийн тэнцэлд дарамт учруулахаар байна. Улмаар уул уурхайн салбарын өсөлт саарахаас гадна уул уурхайг түшиглэсэн уул уурхайн бус салбарт сөргөөр нөлөөлнө. Ирэх онуудад валютын орох урсгал нь гарах урсгалаас бага байх нь төгрөгийн эсрэг ам.долларын ханш чангарах эрсдэлийг бий болгож байна. Мөн эдийн засгийн том агент болох Засгийн газрын хувьд богино, дунд хугацааны эрсдэл өндөр байна. Мэдээж энэхүү эрсдэлийн үр дагавар нь эдийн засагт хүчтэй сөргөөр нөлөөлөхөөр байна.

Монгол Улс 2019 онд хуулийн зохицуулалт, хяналт сул байснаас саарал жагсаалтад орсон нь манай улсад сөргөөр нөлөөлөхөөр байна. Учир нь энэхүү жагсаалтад орсноор

гадаад улс орнуудаас ирэх зээл, тусламж багасах, зээлийн хүү өндөр болох, ам.долларын Монгол Улс руу орж ирэх урсгал багассанаар ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарах зэрэг эрсдэлүүд учирч болзошгүй байна.

Тус компанид нөлөөлөх хамгийн том эрсдэл нь нийгмийн эрсдэл, байгалийн эрсдэл болон хөрөнгө оруулалтын эрсдэл байхаар байна. Учир нь компанийн голлох даатгалын бүтээгдэхүүнүүд болох малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгал нь шууд байгалийн эрсдэлээс хамааралтай байдаг. Мөн ирэх онуудад хадгаламжийн хүү буурах төлөвтэй байгаа нь компанийн орлогод шууд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Санхүүгийн шинжилгээний үнэлгээ хийх:

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Даатгалын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн санхүү, эрсдэлийн шинжилгээг улирал бүр хийлээ.

2019 оны 4 дүгээр улиралд борлуулалтын орлого өмнөх үетэй харьцуулахад 19 хувиар нэмэгдсэн. Энэ нь 2019 оны 3 дугаар сард компани нь Үндэсний давхар даатгал ХК болж үйл ажиллагаагаа тэлэн даатгалын бүтээгдэхүүний тоо болон төрөл зүйлүүд нэмэгдсэнтэй холбоотой. Харин зардлын харьцаа 269 хувь гарсан нь маш өндөр харьцаа юм. Үйл ажиллагааны зардлын хувьд бизнес төлөвлөгөөнийхөө дагуу байгаа боловч даатгалын борлуулалтын хувьд хангалттай сайн ажиллаж чадаагүй учир энэхүү харьцаа өндөр гарсан байна. Бусад харьцаануудын хувьд боломжит түвшнийг ханган ажиллаж байна.

Байгууллагын эрсдэлийн үнэлгээний тайланг цаг тухайд нь гаргаж тайлагнах:

Компанийн учирч болзошгүй хамгийн их эрсдэл нь 11.0 тэрбум төгрөг байгаагаас нөхөн төлбөрийн нөөц санд 3.87 тэрбум төгрөг, хамтын эрсдэлийн санд 1.93 тэрбум төгрөг бүрдүүлж, 5.2 тэрбум төгрөгийн нөөц сангийн эрсдэлтэй байна. Энэхүү нөөц сангийн эрсдэлийг бууруулахын тулд улирал тутамд орлогод тооцсон хураамжаас нөөц санд нэмж хуваарилах байдлаар ажиллаж байна.

Тус компанийн хувьд эрсдэлд суурилсан хөрөнгө /RBC/-ийн харьцаа 255 хувь гарсан нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгөтэй байна. Мөн зээлийн эрсдэл 0 хувь гарсан нь бүх хөрөнгөө банкны харилцах, хадгаламжид тараан байршуулсантай холбоотой байна.

4.5. Хөрөнгө оруулалтын судалгааны чиглэлээр:

Энэ судалгаагаар хөрөнгийн зах зээл дээрх үнэт цаасны эрсдэлийг судалсан бөгөөд судалгааны ажлын зорилго нь хөрөнгийн зах зээлийн эрсдэл, өгөөжийн түвшнийг тодорхойлсон загваруудыг өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан тооцох, ялангуяа Фафа Френчийн гурван хүчин зүйлийн загварыг голлон ашиглаж хувьцааны сонгосон багцын хүлээгдэж буй өгөөжийг тодорхойлох болон түүнд зах зээлийн эрсдэл, өртгийн эрсдэл хэрхэн нөлөөлж байгаа болон VaR /Value at Risk/ аргаар хөрөнгө оруулалтын хүлээж болох хамгийн их алдагдлыг тооцох талаар судалгаа шинжилгээг хийн дүгнэлт өгч, өөрийн саналыг дэвшүүллээ.

Даатгалын компанийн нийт орлогын ихэнх хувийг хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлдэг. Манай компанийн хувьд нийт хөрөнгө оруулалтын багц нь хадгаламжийн бүтээгдэхүүнд төвлөрдөг. Хэрвээ үнэт цаасанд хөрөнгө оруулахаар болбол гэнэтийн өндөр өсөлтөд туйлшрахгүйгээр зайлшгүй тухайн хөрөнгийн зах зээлийн эрсдэл, өгөөжийн түвшнийг тодорхойлсон загваруудын тохиромжтой аргуудыг сонгох эрсдэл ба өгөөжийг

тооцон үзэж хөрөнгө оруулах хэрэгтэй. Тиймээс хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад ашиглагддаг дээрх загвар, аргуудыг ашиглах нь зүйтэй.

4.6. Компанийн эдийн засаг, бизнесийн орчинд судалгаа, шинжилгээ хийх:

Үндэсний давхар даатгал ХК-ийн эдийн засаг болон даатгалын салбар дахь орчны судалгааг хийн холбогдох удирдлагуудад танилцуулсан. Судалгааны ажлын дүгнэлтээр: Худалдан авах чадварыг 0 /тэг/ болгодог хүчин зүйл нь иргэн ажил, орлогогүй болох явдал. Энэ нь хоорондоо холбоо хамааралтай учраас ажилгүйдэл нь бараа бүтээгдэхүүний борлуулалт, цаашлаад компаниудад ч сөргөөр нөлөөлдөг. Тиймээс төрөөс эдийн засгийг тэлэх, дэмжих бодлого явуулах шаардлага бий болоод байна. Даатгалын компаниуд илүүдэл мөнгөн хөрөнгөтэй учраас түүгээрээ хувьцаа, бонд, хөрөнгө оруулалт, тэтгэврийн сан зэрэгт оролцсоноор хөрөнгийн зах зээлийг эрс сайжруулах боломжтой. Гэхдээ инфляц нь даатгагчдад янз бүрийн байдлаар нөлөөлдөг. Энэ нь хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгийн үнэлгээ, урт хугацааны даатгалын өр төлбөрт нөлөөлдөг байна. Дотоодын даатгалын компаниуд 2018 онд 55.3 тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгал компаниудад төлсөн байна. Энэ нь манай компанийн зах зээлийн багтаамж бөгөөд манай компани 1.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь зах зээлийнхээ 3.1 хувьтай тэнцэхүйц байна. Тус компанийн хувьд Монголын даатгалын салбарын нийт хөрөнгийн 14.6 хувийг эзэлж байна.

4.7. Компанийн даатгалын үйл ажиллагаанд шаардагдах актуар тооцоолол хийх:

Компанийн эрсдэлийн удирдлагын зохистой бодлогын хүрээнд төлбөрийн чадварын стандарт үнэн зөв тайлагнан харилцан ажиллах:

Давхар даатгалын хэлбэр тус бүрээр 2019 оны 4 дүгээр улиралд гарсан нөөц сангийн өөрчлөлт болон үлдэгдлийг тооцоолон холбогдох удирдлагуудад танилцууллаа. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн үлдэгдэл 1.18 тэрбум төгрөг, нөхөн төлбөрийн нөөц сангийн үлдэгдэл 3.87 тэрбум төгрөг болсон байна.

Шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол болон хохирол үнэлгээний актуар тооцооллыг хийх:

Компанийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөөнд хөрөнгө, хариуцлага, гэнэтийн осол, ачаа тээвэр, тоног төхөөрөмжийн давхар даатгал нэвтрүүлнэ гэж тусгасны дагуу эдгээр хэлбэрүүд дээр нөөц сан байгуулах шаардлага гарсан. Тиймээс Санхүүгийн зохицуулах хорооны улирал бүр эмхэтгэн гаргадаг даатгалын салбарын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангийн ерөнхий тоо мэдээлэлд үндэслэн дээрх даатгалын хэлбэр тус бүр дээр төлөвлөсөн борлуулалтын дүнд харгалзах нөөц сангийн доод хэмжээг тогтоов. Мөн нийт нөөц сангийн дүнд хэлбэр тус бүрийн хувьд нөөц сангийн эзлэх хувийг тооцоолоход хөрөнгө 57.2 хувь, хариуцлага 3.8 хувь, гэнэтийн осол 6.0 хувь, ачаа тээвэр 2.0 хувь, газар тариалан 22.4 хувийг эзэлж байна.

Давхар даатгалын гэрээгээр шилжүүлэх эрсдэлийн хэмжээ болон хураамжийн хэмжээг актуар тооцооллоор бодох:

МИД-ын эрсдэлийн дунд болон дээд түвшинд давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээг 2019 оны борлуулалтын дүн мэдээнд болон 42 жилийн малын хорогдлын мэдээ дээр үндэслэн тооцоолов. Эрсдэлийн дунд түвшинд хохирлын харьцаагаар 65 хувь давсан 125 хувийн хохирлыг, эрсдэлийн дээд түвшинд 0.3 хувь

давсан 2.5 хувийн хохирлыг давхар даатгагчид шилжүүлж, хамгаалалт авахаар тооцооллоо.

Мөн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан даатгалын борлуулалтад холбогдуулан нийт нөөц санг 4.5 тэрбум төгрөгөөр өсгөж байгуулахаар төлөвлөж байна. Даатгалын хэлбэр тус бүр дээр энэхүү дүнг хуваарилан нөөц санг байгуулах бөгөөд ингэхдээ нийт нөөц санд эзлэх хэлбэр тус бүрийн нөөц сангийн хувийг ашиглах юм. Хэлбэр тус бүрийн нөөц сангийн дүн, даатгалын зах зээлийн мэдээ, учирч болзошгүй хохирлын VaR-ийн 95 хувийн итгэх түвшинд үндэслэн тухайн хэлбэрийн даатгалын эрсдэл даах чадварыг тодорхойлов. Энэхүү компанийн дотоод эрсдэл даах чадварыг давсан эрсдэл орж ирсэн тохиолдолд төлбөрийн чадварыг хангаж байхаар олон улсын давхар даатгалд даатгуулах зарчмаар ажиллаж байна.

Олон улсын давхар даатгалын компаниудаас босгоос давсан хохирлын трити гэрээний хамгаалалтын нөхцөл болон үнийн санал авах зорилгоор 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар хийгдсэн даатгалын хэлбэрийн нийт үнэлгээ, хураамжийн мэдээллийг андеррайтингийн газартай хамтран нэгтгэв.

Компанийн актуар тайланг цаг хугацаанд нь гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд хүргэх:

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт болох “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”, наймдугаар хавсралт болох “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын дагуу 2018 оны 4 дүгээр улирал болон 2019 оны 1, 2, 3 дугаар улирлуудын нөөц сангийн тооцоолол болон үр дүнг танилцуулсан актуарын тайланг бэлтгэж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт болох “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын дагуу төлбөрийн чадварын харьцааг 2018 оны 4 дүгээр улирал болон 2019 оны 1, 2, 3 дугаар улирлуудын байдлаар тооцоолж холбогдох хавсралтуудыг бэлтгэсэн. Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 127 хувьтай байгаа нь дээрх журмын 2.18-т “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын 2.1, 4.1, 4.3-т заасны дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн 2018 оны олон улсын аудитын хийсэн актуарын хяналт шалгалтын тайлан, тайланг гаргасан актуарчийн олон улсын актуарчдын холбооны сертификатын хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

ТАВ. КОМПАЕНС, НӨХӨН ТӨЛБӨРИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

5.1. Компаенс эрсдэлийг шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах:

Компанийн дотоод үйл ажиллагаанд хэрэгжиж буй дүрэм, журмын хэрэгжилтийн талаарх судалгааг гаргасан. Үүний хүрээнд 2 журмыг шинээр, 2 журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Мөн 2 журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил хийгдсэн.

Мөн зарим журмын хэрэгжилтийг хангах үүднээс албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлэх талаар Захирлын зөвлөлийн хурлаас 5 заалттай зөвлөмж гаргаж холбогдох ажилтнуудад танилцуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх ёстой төлөвлөгөө, үзүүлэлт, тайлан мэдээг гаргах хугацаа, анхаарах асуудлыг тусгасан хүснэгтийг боловсруулж, тухайн мэдээллийг хариуцсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулан хүлээлгэн өгсөн.

Мөн Зөрчлийн тухай хуулийн анхаарах заалтуудыг тусгасан хүснэгтийг боловсруулж, холбогдох хүмүүст танилцуулсан.

5.2. Компанийн үйл ажиллагаа холбогдох хууль эрх зүйн баримт бичигт нийцэж байх

Компанийн ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр, эрх зүйн актуудыг хянах, хуулийн зөвлөгөө өгөх:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/06 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө зохицуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөл, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох Аудитын хорооны шийдвэрийн төсөл, “Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал” батлах тогтоолын төслийн эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж ажилласан.

Албан томилолтоор ажиллах, хөрөнгө гаргах, тусламж, дэмжлэг, хүндэтгэл үзүүлэх, ээлжийн амралт, чөлөө олгох, журам батлах, ажлын хэсэг байгуулах, мөнгөн хөрөнгө байршуулах, ажилтнуудыг томилох, чөлөөлөх зэрэг 45 тушаалын төслийн эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж ажилласан.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг боловсруулах, хянах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах:

Гүйцэтгэх захирлын 2019 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний давхар даатгал ХК ийн “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 5.2-т “...Ажилтнуудын ёс зүйн зөрчлийг хянан үзэж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ёс зүйн хорооны ажиллах журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална” гэж заасныг хэрэгжүүлж, уг журмыг шинээр боловсруулан 2019 оны А/57 дугаар тушаалаар батлуулсан.

Гүйцэтгэх захирлын 2018 оны 04/70 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн “Автомашин ашиглалтын журам”-ыг компанийн нэр Үндэсний давхар даатгал болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулж, 2019 оны А/63 дугаар тушаалаар батлуулсан.

Гүйцэтгэх захирлын 2019 оны А/17 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн “Албан хэрэг хөтлөлт, түүнд тавих хяналтыг зохицуулах журам”-ын 7.5-д “...Нууцад хамаарах баримт бичиг болон танилцах эрхтэй албан тушаалтны жагсаалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална” гэж заасныг хэрэгжүүлж, уг журам, жагсаалтыг шинээр боловсруулан 2019 оны А/78 дугаар тушаалаар батлуулсан.

Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/47 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг компанийн нэр Үндэсний давхар даатгал болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулж, 2019 оны А/77 дугаар тушаалаар батлуулсан.

Мөн “Хөдөлмөрийн дотоод журам”-д Гүйцэтгэх захирлын 2019 оны А/76, “Албан хэрэг хөтлөлт, түүнд тавих хяналтыг зохицуулах журам”-д Гүйцэтгэх захирлын 2019 оны А/75 дугаар тушаалаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Бусад этгээдтэй байгуулах гэрээ, хэлцэл, санамж бичгийн төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Ард даатгал ХК, Миг даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК-ууд, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Нотариатчдын танхим, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, ХААН банк, Төрийн банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Богд банк, Үндэсний аудитын газар зэрэг 34 байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэн албан бичгийн төслийн найруулгыг хянаж ажилласан.

Цэнхэр бэх ТББ, Жениун спортс ХХК, Интерекс дизайн ХХК, Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой хийх ажил гүйцэтгэх, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хийх хамтран ажиллах, Фин Тек Солюшнс ХХК, Говь ХК, Ти ди би лизинг ХХК-уудтай хийх нууц хадгалах, Худалдаа хөгжлийн банк, Хас банктай хийх мөнгөн хадгаламжийн, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай хийх хувьцааны хадгаламжийн, даатгалын компаниудтай хийх МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын, МИД-ын борлуулалтыг идэвхжүүлэгч болон бусад гэрээт ажилтнуудтай хийх хөлсөөр ажиллах, даатгалын компаниуд руу хүргүүлэх хамтын ажиллагааны гэрээний төсөл зэрэг компаниас гадагшаа чиглэсэн гэрээг хянаж ажилласан.

Компанийн үйл ажиллагаатай холбогдох хэрэг, маргаантай асуудлаар хуулийн байгууллагад төлөөлөх:

Ажлаас халагдсан ажилтны 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д холбогдох нэхэмжлэлд Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллалаа. Мөн ажилтны нэхэмжлэлд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан.

5.3. Нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолох, олгох чиглэлээр

Нөхөн төлбөрийн тооцоолол, нөхөн төлбөрийн олголт, түүнд тавих хяналт:

МИД-ын 2018 оны борлуулалтын жилд Монгол Улс даяар нийт 33718 малчин өрх даатгалд хамрагдсан бөгөөд эдгээр малчин өрхийн 8.9 хувь буюу 10 аймгийн 3005 малчин өрхөд нийт **323,307,512.12 /гурван зуун хорин гурван сая гурван зуун долоон мянга таван зуун арван хоёр төгрөг арван хоёр мөнгө/** төгрөгийг нөхөн төлбөрт олгогдохоор тооцоологдсон ба хамгийн өндөр нөхөн төлбөр олгогдох аймгаар Увс аймаг нийт 138,415,577.76 /нэг зуун гучин найман сая дөрвөн зуун арван таван мянга таван зуун далан долоон төгрөг далан зургаан мөнгө/ төгрөг, хамгийн өндөр нөхөн төлбөр олгох малчнаар Увс аймгийн Өмнөговь сумын малчин Нацагсүрэн овогтой Сэрүүн-Од нийт 1,334,430 /нэг сая гурван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун гучин/ төгрөг нөхөн төлбөрт олгогдохоор тооцоолол гарсан байна. Уг тооцооллын дагуу Гүйцэтгэх захирлын 2019 оны 9-р сарын 10-ны өдрийн А/67 тоот тушаалаар нөхөн төлбөрт олгогдох нийт **323,307,512.12 /гурван зуун хорин гурван сая гурван зуун долоон мянга таван зуун арван хоёр төгрөг арван хоёр мөнгө/** төгрөгийг ХЭС-аас олгосон.

Макс Агро ХХК-ийн Holstein үүлдрийн үхрийн эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалд гарсан хохиролд олгох нөхөн төлбөрийг гэрээнд заагдсаны дагуу тооцоолол хийн, даатгалын тохиолдол тус бүрд эрсдэлийн хорооны хурлаар шийдвэрлүүлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт 18,450,000 /арван найман сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийг нөхөн төлбөрт шилжүүлсэн.

Нөхөн төлбөрийн санхүүжилтийг хуваарилах, холбогдох сан, эх үүсвэрээс татах чиглэлээр:

Үндэсний статистикийн хорооны хагас жилийн мал тооллогоор Монгол Улсын хэмжээнд 2-р босго үзүүлэлт давсан хорогдол гараагүй учир нөхөн төлбөрт олгогдох 323,307,512.12 /гурван зуун хорин гурван сая гурван зуун долоон мянга таван зуун арван хоёр төгрөг арван хоёр мөнгө/ төгрөгийг буюу нөхөн төлбөрт олгогдох бүх хөрөнгийг ХЭС-аас олгохоор болсон.

ХЭС-ийн хуралд оролцож МИД-ын 2018-2019 оны нөхөн төлбөрийн мэдээлэл танилцуулсан.

МИД-ын нөхөн төлбөр олгох ажлын хүрээнд оролцогч даатгалын компаниуд болон зуучлагч банкнуудад даатгуулан нөхөн төлбөр авахаар тооцоологдсон малчдын жагсаалтыг файл хэлбэрээр тус бүрийн МИД хариуцсан ажилтан руу электрон шуудангаар хүргүүлсэн.

Нөхөн төлбөрийн санхүүжилтийг хуваарилах ажлын хүрээнд хамтран ажиллагч даатгалын компаниудаас ХЭС-аас хуваарилсан даатгагчдаас даатгуулагчдад олгох нийт нөхөн төлбөрийн хэмжээний дагуу нэхэмжлэл авч, байгууллага тус бүрийн данс руу даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийг шилжүүлсэн.

ХЭС-ийн хурлаар шийдсэн нөхөн төлбөр олгох малчид руу мессеж явуулах ажлын хүрээнд нөхөн төлбөр авах нийт 3005 малчдын утасны дугаарын жагсаалт гарган өгсөн.

Даатгалын компаниудаас нэгтгэн явуулсан 2017-2018 болон 2018-2019 оны МИД-ын нөхөн төлбөрийн шилжүүлгийн баримтуудыг нягтлан шалгаж дутуу материалуудыг холбогдох компаниудаас аван нэгтгэв.

2017-2018 оны МИД-ын нөхөн төлбөртэй холбоотой мэдээ мэдээлэлтэй танилцан, хамтран ажиллагч байгууллагуудаас ирсэн нөхөн төлбөр шилжүүлсэн баримтыг шалгах явцад гарсан хэд хэдэн бүртгэл алдаатай болон шилжүүлэх боломжгүй байсан даатгуулагч нартай холбогдон бүрдүүлэх материалын жагсаалтыг өгч, холбогдох даатгагч нараас нөхөн төлбөрийг гаргуулсан.

5.4. Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл тайлант онд нийт 3 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж, компанийн 2018 оны санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж дүгнэлт өгөх, компанийн оноосон нэр “Үндэсний давхар даатгал” болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан брэндбүүкийн загварыг батлах, компанийн “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг батлах, 2020 оны Бизнес төлөвлөгөө, давхар даатгалын төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, орон тоог батлах, МИД-ын гэрээг өөрчлөх, МИД-ын гэрээнд хэрэглэгдэх малын жишиг үнийг шинэчлэн тогтоох, Эрсдэл болон төлбөрийн чадварыг тооцох аргачлалыг батлах, олон улсын давхар даатгалын SKOP /SKOR/ компанитай трити гэрээ байгуулах зөвшөөрөл олгох зэрэг 10 тогтоол гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн өнгөрсөн онуудын шийдвэрийг эмхэтгэн архивлаж архивд шилжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл авахтай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бичиг баримт болон холбогдох материалуудыг бэлтгэн хүргүүлсний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 347 дугаар тогтоолоор ТУЗ-ийн 7 гишүүнийг эрх бүхий албан тушаалтнаар томилох зөвшөөрөл олгосон.

5.5. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх:

Авлигаас урьдчилсан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа-2019 төлөвлөгөөг бэлтгэн АТГ /Авлигатай тэмцэх газар/-т хүргүүлсэн.

Дэд захирлын хөрөнгө, орлогын мэдүүлэгт их хэмжээний өөрчлөлт орсныг хуулийн дагуу холбогдох байгууллагад мэдүүлэв. Ёс зүйн шинэчлэгдсэн дүрмийн хүрээнд Ёс зүйн хорооны дарга, Компаенс нөхөн төлбөрийн газрын дарга нар ажилтнуудын ёс зүйн талаар компанийн нийт ажилтнуудад ажлын байран дээр хэрхэн биеэ авч явах, ёс зүйг хэрхэн мөрдөж ажиллах талаар сургалт мэдээлэл өглөө.

ЗУРГАА. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх:

Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, биелэлттэй холбоотой ажлын хүрээнд:

Компанийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Гүйцэтгэх захирлын А/04 дүгээр тушаалаар батлуулсан. Ажилтнууд шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байна. Компанийн бүтэц, ажлын байрны тодорхойлолт, цалингийн зэрэглэл, шатлал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Шинээр ажилд орсон 6 ажилтан, туршилтын хугацаа дууссан 2 ажилтантай хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулсан. Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн 1 ажилтны, мөн ажлаас халагдсан 1 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлав. Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор өөр албанд шилжин томилогдсон 4 ажилтантай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Жирэмсний амралтаа авсан, ажлаас халагдсан, ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын оронд ажиллах хүмүүсийг ажилтнуудаасаа ажил үүргийг шилжүүлэн зохион байгууллаа.

Ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг эхний хагас жил болон 2019 оны жил эцсийн байдлаар гаргуулан авч холбогдох хүмүүсээр үнэлүүлэн, үнэлгээний дагуу урамшуулалт цалин олгосон.

Ажилтнуудын дунд эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх олон талт арга хэмжээг зохион явуулах:

Компанийн 2019 оны олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажилласан.

Ажилтнуудыг мэргэжил арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах:

Компанийн 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөөг компанийн ажилтнуудад газруудаас өгөх мэргэжил арга зүйн дотоод сургалтын чиглэлээр, бүх ажилтнууд хамрагдах бусад сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтад ажилтнуудаа хамруулах гэсэн 3 чиглэлээр гарган батлуулсан. Үүний дагуу мэргэжил арга зүйн чиглэлээр чадавхжуулах гадна, дотоодын сургалт, үйл ажиллагаанд ажилтнуудаа хамруулан ажиллалаа.

6.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах

Компанийн жилийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах:

Батлагдсан санхүүгийн төлөвлөгөөг орлого болон зардлын төрөл, зүйл, бүлэг бүрээр сар бүрд хуваарилан Гүйцэтгэх захирлаар батлуулсан ба улирал бүрийн эцсийн байдлаарх төсвийн гүйцэтгэлийг гарган гүйцэтгэх удирдлагад тухай бүр танилцуулж ажиллалаа.

2020 оны санхүүгийн төлөвлөгөөг газар нэгж бүрээс зардлын зүйл ангиллаар саналыг нь авч, нэгтгэн боловсруулж удирдлагаар хянуулан бэлэн болгосон ба ТУЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах:

Санхүүгийн программыг шинэчлэн хандалтын 2 түвшинтэй болгосон. 1 дүгээр түвшний хандах эрх дээр Ерөнхий нягтлан бодогч ажиллах эрхтэй бөгөөд засварлах, хаалт хийх, тайлан бэлтгэх, санхүүгийн давхар бичилтүүдийг хийж тааруулах зэрэг түвшинд ажиллаж байна. 2 дугаар түвшний хандах эрхээр Нягтлан бодогч, Худалдан авалт хариуцсан ажилтан нар ажиллах бөгөөд зөвхөн харилцах дансны хуулга боловсруулах, дараа тооцоо болон урьдчилж гарсан данснуудын хаалтын бичилтийг зөвхөн тухайн сардаа хийж гүйцэтгэх үүрэгтэй болсон. Мөн өмнөх сар болон улирлын дансны бичилтүүдийг зөвхөн харах эрхтэй бөгөөд засварлах, устгах боломжгүй болсон. Ингэснээрээ компанийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн үнэн зөв бүртгэл хөтлөлт, зөв тайлагналын эхлэл болсноороо үр дүнтэй ажил боллоо.

Компанийн бүртгэл болон санхүүгийн үйл ажиллагааг компанийн Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн дагуу үнэн зөв хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн Үндэсний давхар даатгал ХК болсонтой холбоотойгоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дотоодын нөөц бололцоондоо тулгуурлан шинээр боловсруулж 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Аудитын хороонд танилцуулж, ТУЗ-ийн тогтоолоор баталсан.

Ажилтнуудын цагийн бүртгэлийг сар бүрийн цалинг олгохоос өмнөх өдөр цагийн бүртгэлээс татан авч цагийн тооцоог ажилтан тус бүр дээр дэлгэрэнгүй хөтөлж нэгтгэн Захиргаа, удирдлагын газрын дарга болон Ерөнхий нягтлан бодогчид сар бүр танилцуулж хянуулж ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны шалгалтад 2016, 2017, 2018, 2019 оны баланс, орлого үр дүн, зардлын задаргаа, авлагын дэлгэрэнгүй, авлагын насжилт, өглөгийн дэлгэрэнгүй, даатгалын хураамж, ашиг, үнэт цаас, урьдчилгаа цалин, төлбөрийн чадвар, дансны үлдэгдэл, нөөц сан, үндсэн хөрөнгө зэрэг мэдээллийг бэлтгэж өгөв. Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны асуулга, эрсдэлийн үнэлгээний асуулгыг бөглөн өгсөн.

2019 оны санхүүгийн тайланд аудит хийж байгаа Грант Торнтон Аудит ХХК-д шаардлагатай баримт, мэдээллийг цаг тухай бүрд гарган өгч ажиллаж байна.

Жил, улирлын санхүүгийн тайланг гаргах, гүйцэтгэх удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийхээр шалгарсан Эрнст Энд Янг Монголия аудит ХХК-тай 2018 оны 11 сарын 27-ны өдөр гэрээ байгуулан 2019 оны 02 сарын 04-ний өдөр аудитлагдсан тайлан бэлэн болсон. Тухайн аудитлагдсан тайлан нь санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн,

мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан хэмээх дүгнэлт өгсөн.

2018 оны Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хороо мөн харьяа Татварын байгууллагуудад тушаасан ба Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тайлангийн хуримтлагдсан ашгаас дүрмийн сан, нөөц сангийн хөрөнгийг тус тус нэмэгдүүлэх санал хүргүүлснийг хэлэлцэн шийдвэрлэж, Сангийн сайдын 2019 оны 4 сарын 30-ны өдрийн 94 дугаар тушаалаар Үндэсний давхар даатгал ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн хуримтлагдсан ашгаас 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгөөр компанийн дүрмийн санг, 4,000,000,000 /дөрвөн тэрбум/ төгрөгөөр нөөц сангийн хөрөнгийг тус тус нэмэгдүүлсэн.

Ажилтан тус бүрийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж баталгаажуулсан.

Мөн 2020 оны төсвийн задаргааг бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, ном, хэвлэл авах, урсгал засвар, төлбөр хураамж, бусад төлбөр, төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, банк санхүүгийн байгууллагын хураамж, элэгдлийн зардал, татвар ногдох орлогоос хасагдах зардал, байрны түрээс, БҮТЭЗ /бага үнэтэй түргэн элэгдэх зүйл/ хангамжийн материалын зэргээр ангилан гаргалаа.

Компанийн шинээр борлуулсан бүтээгдэхүүнд тааруулан Санхүүгийн программ хангамждаа даатгалын тайлагналын тохируулгуудыг хийж өгснөөр нэмэлт тайлангууд, нөөцийн сангийн бодолт зэрэг мэдээллүүд нь үнэн зөв тайлагнагдаж байна. Тус компанийн программ хангамж нь бизнесийн байгууллагад зориулан хийгдсэн бөгөөд үүнийг даатгалын бүртгэлийн онцлогт тохируулан тухай бүрд нь тохируулга хийн ашиглаж байна.

Хагас жил тутамд татварын үлдэгдлийг Татварын ерөнхий газарт очиж тулган баталгаажуулдаг ба ямар нэгэн зөрүү гараагүй болно.

6.3. Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх чиглэлээр:

Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулах:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Тээвэр шатахуун худалдан авах ХААДДХК/201902011 дугаартай тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж дууссан. Шалгаруулалтын үр дүнд Петростар ХХК шалгарсан ба 3 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулав.

Мөн Сурталчилгааны материал хэвлүүлэх ХААДДХК/201902020 тендерийг зохих журмын дагуу харьцуулалтын аргаар цахим хэлбэрээр зохион байгуулсан ба 9 хэвлэлийн компани материалаа ирүүлсэн боловч 3 дугаар сарын 20-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 37 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг Үндэсний давхар даатгал ХК болгож өөрчилсөнтэй холбоотойгоор уг худалдан авалтыг цуцалсан. 3 дугаар сарын 22-ны өдөр дахин харьцуулалтын аргаар уламжлалт хэлбэрээр тендер зарлан зохион байгуулж, 3 компани материалаа ирүүлснээс Эс Пи Ар ХХК шалгарч 3 дугаар сарын 29-ний өдөр 41,181,250 /дөчин нэгэн сая нэг зуун наян нэгэн мянга хоёр зуун тавь/ төгрөгийн гэрээ байгуулан ажиллалаа.

Компанийн бүртгэлийн нэгдсэн цогц программ хангамж худалдан авах ЦП-2019/03/11 дугаартай тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар цахим хэлбэрээр зохион байгуулав. Шалгаруулалтын үр дүнд Фин Тек Солюшн ХХК шалгарч 4 дүгээр сарын 30-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Бичиг хэрэг болон цэвэрлэгээний шаардагдах материалыг батлагдсан төсвийн дагуу Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс чанар байдал, үнэ зэргийг харгалзан захиалах, худалдан авч нөөцлөх, авсан материал бүрд холбогдох баримт гаргуулж авч баримтжуулж ажиллалаа.

Санхүүгийн тайландаа олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний АҮ-2019/09/25 дугаартай тендер шалгаруулалтыг 9 дүгээр сарын 26-ны өдөр tender.gov.mn дээр зарласан. Тендерийг 11 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн. Тендерт Эрнст энд Янг Монголия Аудит ХХК, БДО Аудит ХХК, Грант Торнтон Аудит ХХК оролцсон. Олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллага болох Грант Торнтон Аудит ХХК 54.516.000,0 /тавин дөрвөн сая таван зуун арван зургаан мянга/ төгрөгөөр Зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгаран ажиллаж байна.

Ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан зохион байгуулах:

Тайлант оны 3 дугаар сард хөрөнгийн тооллогыг эд хариуцагч солигдсонтой холбоотойгоор хийсэн. Мөн ашиглалтын хугацаа дууссан 14 нэр төрлийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 104 дүгээр тогтоолын дагуу акталж устгалд оруулсан. Дахин эд хариуцагч солигдсонтой холбоотойгоор 5 дугаар сард Гүйцэтгэх захирлын А/37 дугаар тушаалын дагуу хөрөнгийн тооллогыг хийсэн. Энэхүү тооллогоор зөрчил, дутагдал илрээгүй.

Ажилтан ажлаас гарах мөн шинээр ажилтан ороход тухай бүрд хөрөнгийн бүртгэлийг хийж байна.

Оффисын үйлчлэгчээр долоо хоногийн 3 өдөр цэвэрлэгээ хийлгэж, өдөр бүр хогоо авхуулж байна. Мөн компанийн байранд эрүүл мэндийн хайрцаг байрлуулж, шаардлагатай эм бэлдмэл, боолт, даралтын аппарат зэргийг авч заавартай нь хамт байрлуулсан.

Гэрэл, цахилгаан, ус тасрах, ариун цэврийн өрөөний суултуур, крант бөглөрөх, хөшиг тогтоох зэрэг асуудлыг оффисын байрны менежер болон сантехникч, үйлчлэгч нартай холбогдон тухай бүрд нь шийдүүлж ажиллалаа.

Ажилтан бүрийн нэр дээр ашиглалтын карт нээж ашиглаж байгаа хөрөнгүүдийн хөдөлгөөнийг бүртгэж, хүлээлгэн өгсөн.

Санхүүгийн өрөөний агуулахын ашиглалтыг сайжруулан эмх цэгцтэй болгон тохижуулсан. Мөн серверийн өрөөний хэвийн ажиллагааг хангах зорилгоор BSB-ээс air condition 12GPW авч суурилуулсан.

6.4. Компанийн компьютер, техник хэрэгсэл, хэрэглээний программ хангамжийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах

Компанийн компьютеруудын вирусийн хамгаалалтуудыг ханган ажилласан. Гаднын нөлөөллүүд илрээгүй болно.

Цахим шуудангаар вирус ирэх болсон тул ажилтнуудад цахим шуудангаар анхааруулах мэдээлэл явуулж, анхааруулах бичиг наах зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.

Байгууллагын вэбсайтад шинэ мэдээ мэдээллүүдийг нэмсэн. Мэдээ оруулдаг удирдлагын админ хуудсыг шинээр хийснээр интернэтэд холбогдсон ямар ч компьютероос хаана ч байсан мэдээг оруулах боломжтой болов. Мөн өнгөрсөн саруудын харгалзах файлуудыг оруулж санг цаг тухай бүрд нь шинэчилж байна.

Mongolianre.com мэйл хаягуудыг ажилтан бүрд суулгаж өгсөн. Ажилтнуудын компьютеруудын тухай үзүүлэлт бүртгэлүүдийг хөтөлсөн.

Шинээр ажилтан орсон тохиолдол бүрд байгууллагаас оногдуулсан компьютеруудыг форматалж, шаардлагатай программуудыг суулгаж, хүлээлгэн өгч байна. Компьютер, хувилагч хэвлэгчдийн тухай хувийн хэрэг хөтөллөө.

Ажилтнуудад программ хангамжийн талаар, асуулга бүрд нь хариулж мэдээллээр хангаж байна. Шинээр авсан принтерийн тохиргоог хийсэн бөгөөд ажилтнуудын компьютерт принтерийн тохиргоог хийж өглөө.

Байгууллагын ажилтнуудын компьютерүүд дээр байх ёстой программуудыг хянаж, ажиллахгүй байгаа зарим программуудыг засварлаж мөн шинээр суулгасан.

6.5. Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах

Компанийн дотоод нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулах, бичиг хэргийн хөтлөлт, архивын нэгжийн үйл ажиллагаа:

Ажилтнуудын хувийн хэргийг шалган дутуу бичиг баримтыг бүрдүүлж цэгцэлж дуусгалаа. Төрийн албан хаагчийн анкет шинэчлэгдсэнтэй холбоотой бүх ажилтнуудаас шинэ Төрийн албан хаагчийн анкетыг бөглүүлэн авч хувийн хэрэгт нь хийсэн.

Ажилтнуудын боловсрол, ажилласан жил, гэр бүлийн байдал, авсан гавьяа шагнал зэргийн судалгааг цаг тухай бүрд нь хөтөлж байна.

Тайлант онд нийт 276 албан бичиг, Гүйцэтгэх захирлын 151 тушаал /А/Б/-ыг холбогдох удирдлагуудаар хянуулж албан бичгийн стандартын дагуу хэвлэж гаргав. Мөн 142 албан бичгийг хүлээн авч удирдлагаар цохолт хийлгэн шийдвэрлэж ажиллалаа. Компанийн ирсэн, явсан бичиг болон Захирлын тушаал, ТУЗ-ийн тогтоол зэргийн цахим бүртгэлийг цаг тухай бүрд нь хөтөлж байна.

Компанийн нэр өөрчлөгдсэнтэй холбоотойгоор компанийн тамга, ТУЗ-ийн тамга, Ирсэн бичгийн дардас, “Нууц”-ын дардас, “Баталгаажуулав” дардас, “Хуулбар үнэн” дардаснуудыг “Тод тамга” ХХК-д захиалан хийлгэж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2018 оны баримтуудыг 2019 оны 3 дугаар сард архивын 8 нэгж болгон архивлаж дууссан.

Байгууллагын баримт бичгийг хадгалах архивын өрөөтэй болох судалгааг хийж удирдлагуудад танилцуулан архивын өрөөтэй болж, архивын стандартын дагуу тохижуулав.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын талаарх ойлголтыг газруудын бичиг хэрэг хариуцсан ажилтнуудад өгч, газруудаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг нь гаргуулан авсан. Нэгтгэж компанийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргахаар бэлдэж байна.

“Ёс зүйн хорооны ажиллах журам”, “Байгууллагын нууцын журам”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”, “Автомашин хэрэглэх журам”-уудыг шинээр болон шинэчлэн батлуулсан. Ажилтнуудаар нууцын баталгааны хуудсыг бөглүүлэн авлаа. Мөн “Хөдөлмөрийн дотоод журам”, “Албан хэрэг хөтлөлт, түүнд тавих хяналтыг зохицуулах журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны шалгалт 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны хооронд хийгдсэнтэй холбогдуулан албаны хүмүүст холбогдох мэдээллийг цаг тухайд нь цаасаар болон файлаар өгч хамтран ажилласан.

Компанийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах, үйл ажиллагааны тайланг гаргах, нэгтгэх:

Компанийн 2019 оны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллалаа. 2019 оны эхний хагас жил, жилийн эцсийн тайланг хүснэгтэн болон бичмэл хэлбэрээр нэгтгэн гаргаж удирдлагаар хянуулж баталгаажуулсан.

Компанийн авто машин, техникийн бэлэн байдлыг хангаж ажиллах чиглэлээр:

Компанийн нэр дээрх автомашинуудыг цаг тухайд нь үзлэг оношилгоонд оруулан шаардлагатай засвар үйлчилгээг хийлгэж байна. Мөн түүнчлэн тайлант оны автомашины Агаарын бохирдлын татвар, Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар төлөлтийг тус тус төлж дуусгасан.

6.6. Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын хүрээнд

ТУЗ-ийн Аудитын хороо тайлант онд 3 удаа хуралдаж хурлаас гарсан шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлж ажиллалаа.

Компанийн 2018 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны хурлаар хэлэлцэн дэмжигдсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулав. Компанийн 2019 оны 4 дүгээр улирлын үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлтөд дотоод хяналт шалгалтыг хийж аудитын хорооны дарга, гишүүдэд тайлагнасан. Компанийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавин ажиллалаа.

Компанийн Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл бүрэн хөтлөгдөж, гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох газар нэгж, албан тушаалтнуудад хуваарилан өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тайлант онд Захирлын зөвлөлийн хурал 36 удаа хуралдаж, үйл ажиллагаатай холбоотой 129 үүрэг даалгавар өгөгдөж 98.2 хувиар, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулал олгох, компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 17 шийдвэр гарч 98.8 хувиар тус тус биелсэн байна.

Компанийн 2018 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажилласан.

ДҮГНЭЛТ

- Засгийн газрын 2018 оны 303 дугаар тогтоолоор компанийн оноосон нэрийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон өөрчилсөн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 37 дугаар тогтоолоор оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрснөөр үйл ажиллагаагаа өргөжүүлж, цар хүрээгээ тэлэх эрх зүйн орчин бүрдлээ.
- Үндэсний давхар даатгал ХК нь 2019 онд анх удаа хөрөнгө, хариуцлага, ачаа тээвэр, агаарын хөлөг, барилга угсралт, гэнэтийн ослын даатгалын хэлбэр тус бүрээр давхар даатгалын факультатив болон трити гэрээнүүдийг байгуулан ажилласан ба даатгалын хураамжийн орлогын төлөвлөгөөг 113 хувиар буюу 241.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.
- 2019 онд МИД-ын борлуулалтаар 32.3 мянган малчин өрхийг даатгалд хамруулж, 3.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөгөө 101 хувиар биелүүлсэн нь МИД-ын борлуулалт хийж эхэлснээс хойш хамгийн өндөр хураамжийн орлого төвлөрүүлсэн жил боллоо.
- 2019 онд компанийн анхны давхар даатгалын трити гэрээг Практикал даатгал ХХК-тай, олон улсын давхар даатгалын трити гэрээг СКОР Рэ /тэргүүлэгч давхар даатгагч/, Жи Ай Си Рэ, Ханновер Рэ, Тайпин Рэ компаниудтай байгууллаа.

- Азийн томоохон давхар даатгагчид болох 14 орны төлөөллийг нэгтгэсэн Азийн давхар даатгагчдын холбоонд гишүүн байгууллагаар элслээ. Энэ нь олон жилийн туршлага бүхий томоохон давхар даатгагчдын туршлагыг судлах, хамтран ажиллах боломжийг нээж өгсөн.
- Монголын Бизнесийн Зөвлөл /BCM/-д гишүүнээр элслээ.
- “Forbes Mongolia” сэтгүүлийн шалгаруулалтаар Монголын даатгалын “Шилдэг 10 компани”-ийн нэгээр тодорлоо.
- Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 5.4 тэрбум төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 59.6 сая төгрөг оруулж, компанийн хөрөнгийг өсгөн арвижууллаа.
- Тайлант оны 4 дүгээр улирлын байдлаар төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 127 хувь байгаа нь “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байна.
- Үндэсний давхар даатгал ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн хуримтлагдсан ашгаас 5.0 тэрбум төгрөгөөр компанийн дүрмийн санг, 4.0 тэрбум төгрөгөөр нөөц сангийн хөрөнгийг тус тус нэмэгдүүлсэн.
- Компанийн “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг дотоодын нөөц бололцоондоо тулгуурлан шинээр боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна.
- Төсвийн орлогын төлөвлөгөө 10.7 хувиар давж биелсэн ба төсвийн зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 10.0 хувиар хэмнэгдсэн үзүүлэлттэй байна.

-----oO-----

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК
14251, Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 5 дугаар хороолол,
Чингисийн өргөн чөлөө-10Б байр,
“Бизнес тауэр”, 20 давхар
Э-шуудан: info@mongolianre.mn
Вэб: www.mongolianre.mn
Утас: 75770002